



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2018 • XI • № 25

Н.БАТСАЙХАН:
БАНКНЫ ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН
СТАНДАРТЫГ
ШИНЭ ТӨВШИНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ
БЭЛТГЭЛ АЖИЛ
ЭХЭЛЧИХСЭН

МӨНГӨНИЙ
БОДЛОГЫН
ШИЙДВЭРИЙН
ТАЛААР ХЭН ЮУ
ХЭЛЭВ?

ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

МОНГОЛ УЛСЫН ЭРДЭНЭСИЙН САНГААС: ӨВГӨНТ УУЛЫН ОЛДВОРУУД



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ МЭДЭГДЭЛ

Бодлогын хүүг өсгөх тухай

Дугаар: 2018/04

Огноо: 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2018 оны 11 дүгээр сарын 27-ны ээлжит бус хурлаар Бодлогын хүүг 1 нэгж хувиар өсгөн 11 хувьд хүргэх шийдвэр гаргалаа.

Хэрэглээний үнийн индексээр хэмжигдсэн жилийн инфляци 2018 оны 10 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд 6.3 хувь, Улаанбаатар хотод 6.8 хувьтай байна. Хэдийгээр түүхий эдийн үнэ харьцангуй өндөр төвшинд хадгалагдаж, эдийн засаг энэ оны гуравдугаар улиралд хүлээлтээс давж 6.7 хувиар өссөн боловч эдийн засгийн гадаад орчны тодорхой бус байдал өндөр байна.

Ирэх оны төсвийн алдагдал харьцангуй өндөр төвшинд батлагдсан, АНУ-ын Холбооны нөөцийн банк мөнгөний бодлогын суурь хүүгээ нэмэгдүүлсэн, БНХАУ нүүрсний зах зээлдээ хязгаарлалт хийж эхэлсэн зэрэг нь төлбөрийн тэнцэлд сөргөөр нөлөөлж төгрөгийн ханшинд дарамт учруулж байна. Иймд, Монголбанк нэг талаас эдийн засгийн идэвхжилийг дунд хугацаанд зохистой төвшинд хадгалах, нөгөө талаас гадаад зах зээлийн тодорхой бус байдлыг харгалзан үзэж Мөнгөний бодлогын хорооны ээлжит бус хурлаар бодлогын хүүг нэмэгдүүлэх шийдвэр гаргалаа.

Монголбанкны энэ удаагийн шийдвэр нь инфляцийг дунд хугацаанд зорилтот түвшний орчимд тогтворжуулах зорилттой нийцтэй бөгөөд төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлэн, үндэсний мөнгөн тэмдэгтэд итгэх итгэлийг хамгаалж, макро эдийн засгийн дунд хугацааны тогтвортой байдлыг хадгалахад чиглэж байна.

Монголбанкнаас 2018 оны 12 дугаар сараас эхлэн Төв банкны 28 долоо хоногийн хугацаатай үнэт цаас арилжаалах шийдвэр гаргалаа.

Хорооны хуралдааны хураангуй тэмдэглэлийг хоёр долоо хоногийн дараа Монголбанкны цахим хуудаст байршуулна.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРОО

Монголбанкны Олон нийтийн боловсрол, мэдээллийн төвөөс эрхлэн гаргав.

Онцлох үйл явдал

ХУУДАС

Монгол Улсад 36.22 сая ам.долларын санхүүжилт олголоо

4

Ярилцлага:

ХУУДАС

Банкны хяналт шалгалтын стандартыг шинэ төвшинд хэрэгжүүлэх бэлтгэл ажил эхэлчихсэн

7

Байр суурь:

ХУУДАС

Мөнгөний бодлогын хорооны шийдвэрийн талаар хэн юу хэлэв?

12

Мөнгөн тэмдэгтийн түүх:

ХУУДАС

Цаасан мөнгөн тэмдэгт (1287 он)

14

Улаанбаатарын зөвшилцөл:

ХУУДАС

"Улаанбаатарын зөвшилцөл"-ийг дэмжих нь

15

Монголбанк юу хийдэг вэ?:

ХУУДАС

Ц.Гарьд: Монгол улсын төлбөр тооцоо олон улсын жишигт хүрсэн

17

Асуулт, хариулт:

ХУУДАС

Монголбанкны хэвлэлийн бага хурлаас (2018.11.27)

22

Эрдэнэсийн сан:

ХУУДАС

Өвгөнт уулын олдворууд

28

Банкир:

ХУУДАС

Торстен Клайн Бойнинг: Активын чанарын үнэлгээ банкуудын эрсдэлийн удирдлагын туршлагад маш том дэвшил авчирсан

29

Судалгаа:

ХУУДАС

Монгол улсын гадаад худалдааны бодлогод анхаарах асуудлууд

34

Дэлхийн эдийн засаг:

ХУУДАС

Эдийн засгийн дараагийн хямрал

39

Санхүүгийн боловсрол:

ХУУДАС

Үндэсний төлбөрийн систем гэж юу вэ?

41

Монгол Улсад 36.22 сая ам.долларын санхүүжилт олголоо.



Олон Улсын Валютын Сан (ОУВС)-ийн Захирлуудын зөвлөл 2018.10.31-ний өдөр хуралдаж, Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлж буй Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хэрэгжилтийн тав дахь шатны үнэлгээний тайланг хэлэлцэж батлав. Тус үнэлгээгээр хөтөлбөрийн хэрэгжилтийг эергээр үнэлсэн байна. Тодруулбал, төсвийн тоон үзүүлэлтүүд зорилтоос давж, гадаад валютын нөөц нэмэгдсэн гэх зэргээр хөтөлбөрийн зорилтууд хангагдсан хэмээн дүгнэв. Үүний үр дүнд 36.22 сая ам.долларын санхүүжилт 2018 оны 11 дүгээр сарын 02-нд Монголбанкны дансанд шилжин орж, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүллээ. Ингэснээр тус хөтөлбөрийн хүрээнд ОУВС-гаас Монгол Улсад олгосон санхүүжилтийн дүн 217.33 сая ам.долларт хүрэв.

Нүүдэлчдийн төлбөрийн хэрэгслийн түүхийг цуврал номонд мөнхлөв.

Монголбанкнаас санаачлан, эртний эдлэл, монголчуудын эд өлгийн соёлын дурсгалыг судлагч, цуглуулагч Ц.Батсайхантай хамтран бүтээсэн "Монголын их эзэнт улсын зоос, мөнгөн тэмдэгт", "Монгол Улсын төлбөрийн хэрэгсэл", "Монгол Улсын гүйлгээний болон дурсгалын зоос" гурван цуврал түүхийн бүтээлийг уншигчдын гарт хүргэлээ. Эдгээр номонд Монголын Их Эзэнт улсын үеэс өнөөг хүртэлх монголчуудын төлбөрийн хэрэгсэл, үнэт цаас, төлбөрийн бусад хэрэгслийн тухай өгүүлсэн бөгөөд түүхэн он дарааллаар нь холбогдох гэрэл зураг, түүхий эд өлгийн зүйлсийн хамт баримтат эх сурвалжид үндэслэн бүтээжээ. Монгол Улсад банк, санхүүгийн байгууллага, Монголбанк үүсэн байгуулагдсаны 95 жилийн ойг угтан бүтээж буй уг цуврал боть нь монголчуудын уламжлал, соёлын талаар шинэ сонирхолтой, танин мэдэхүйн ач холбогдолтой мэдээлэл өгөхийн сацуу Монголын түүх соёлыг судлах, хамгаалах, сурталчлан таниулахад хувь нэмрээ оруулахад зориулагдаж байна.



Мөнгөний бодлогоор инфляцийг 2019-2020 онд 8 хувь орчимд тогтворжуулна.



Ирэх онд баримтлах мөнгөний бодлогын үндсэн чиглэл нь бүхэлдээ санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэж, санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох бодлогын алхмууд хийх гэж байгаагаараа онцлог. Мөн Монголбанк гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх зорилтыг дангаар болон төрийн эрх бүхий байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх байдлаар үндсэн чиглэлд тусгав. Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг урт хугацааны тэнцвэрт төвшин болох 8 хувийн орчимд тогтворжуулах зорилтыг ирэх 2 жилд үргэлжлүүлэн хэрэгжүүлж, дунд хугацаанд 6 хувь болгон бууруулах, Төв банкны нээлттэй, ил тод байдлыг хангаж, олон нийттэй харилцах харилцааг үр ашигтай болгох, банкуудын өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг сайжруулах арга хэмжээг үргэлжлүүлэх зэрэг чухал зорилтуудыг 2019 оны Мөнгөний бодлогын Үндсэн чиглэлд тусгажээ.

Банк хооронд 3 хүртэлх сая төгрөгийн гүйлгээг 3-4 секундэд шилжүүлнэ.



Үндэсний цахим гүйлгээний төвийн системээр 7 хоногийн турш 24 цагаар дамжих гүйлгээний дүнгийн дээд хязгаар 1 сая төгрөг байсныг нэмэгдүүлж 3 сая төгрөг болголоо. Ингэснээр 3 сая хүртэлх төгрөгийн банк хооронд хийгдэх төлбөрийг өдөр бүр 24 цагийн турш тасралтгүй, түргэн шуурхай гүйцэтгэх боломжтой болж байгаа бөгөөд 3 хүртэлх сая төгрөгийн төлбөрийг байршил, өдөр хамааралгүй аль ч цагт 1-4 секундэд гүйцэтгэх бүрэн боломжтой болж байна. Энэ нь Монгол Улсад цахим төлбөр тооцоо гүйцэтгэх үйл ажиллагаа дахин нэг шат ахиж, эдийн засаг дахь мөнгөний эргэлтийг хурдасгах чухал ач холбогдолтой. Иргэд болон банкуудаас ирүүлсэн хүсэлтийг сайтар судалж, холбогдох судалгаа тооцооллыг хийсний үндсэн дээр энэхүү шийдвэрийг гаргасан бөгөөд цахим төлбөр тооцоог нийтийн хэрэглээ болгож хэвшүүлэхэд дэмжлэг үзүүлж буй юм.

Монголбанкны Хяналтын зөвлөл хуралдлаа.

Монголбанкны Хяналтын зөвлөлийн ээлжит хурал 2018 оны 11 дүгээр сарын 23-нд боллоо. Тус хурлаар Монголбанкны Дотоод аудитын газрын 2018 оны эхний 3 улирлын үйл ажиллагааны талаар газрын захирал Д.Аюуш, Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын 2018 оны 10 дугаар сарын 30-ны байдлаарх үйл ажиллагааны тухай тус газрын захирал А.Энхжин нарын мэдээллийг сонсов. Тухайн мэдээлэлтэй холбогдуулан Хяналтын зөвлөлийн дарга Д.Даваасамбуу, гишүүн Л.Ариунаа, Л.Дондог нарын гаргасан санал, дүгнэлтийг мөн авч хэлэлцэж зохих шийдвэр гаргав. Монголбанкны санхүүгийн байдлыг сайжруулах талаар ихээхэн хүчин чармайлт гаргах хэрэгтэй болсныг тэмдэглэж, энэ талаар Монголбанкны дотоод аудитын газарт албан бичиг хүргүүлэхээр болов. Мөн тус газраас хийсэн аудит, хяналт шалгалтын ажилд дүн шинжилгээ хийж, мөрөөр нь ажиллах, техник, мэдээллийн технологийн чадамжийг дээшлүүлэх талаар дэмжлэг үзүүлэхийг Монголбанкны удирдлагад зөвлөхөөр шийдвэрлэв.



Арилжааны банкууд “Дижитал гарц”-ыг нээлттэй танилцуулав.



Монголбанкнаас хэрэгжүүлж буй “Цахим эринд цахим төлбөр тооцоо” аяны хүрээнд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, цахим төлбөр тооцоо болон финтек технологийг дэмжих, олон нийтэд таниулах зорилгоор “Дижитал гарц” өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгт санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэгчид өргөн хүрээнд оролцож, өөрсдийн цахим технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд танилцуулав. Монголбанк үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх, финтек технологийг дэмжих чиглэлд онцгой анхаарч буй бөгөөд өнгөрсөн хугацаанд үндэсний төлбөрийн системд цахим мөнгө ашиглах, нэвтрүүлэх журмыг баталж, цахим мөнгөний анхны зөвшөөрлийг олгохын сацуу үндэсний ₮ картыг олон улсын EMV/NFC чип технологид шилжүүлэх, санхүүгийн байгууллагад ашиглах тоон гарын үсгийн системийг нэвтрүүлэх зэрэг ажлыг хийж, хэрэгжүүлээд байна.

Жижиг, дунд үйлдвэрлэлийн санхүүжилтийн байдлыг судалмаа.



Монголбанк Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ) эрхлэгчдийн бизнесийн дотоод болон гадаад орчин, санхүүжилтийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон, мөн төрөөс баримталж буй бодлого, дэмжлэгийн хүртээмжийг тандсан 2018 оны цогц судалгааг хийж, олон нийтэд танилцууллаа. Судалгааны үр дүнг тоймловол ЖДҮ-ийн хөгжилд Засгийн газар, Олон улсын байгууллагууд, Санхүүгийн болон Төрийн бус байгууллагууд чухал үүрэгтэй бөгөөд санхүүжилт олгох, сургалт, зөвлөгөө өгөх, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах замаар дэмжлэг үзүүлдэг болохыг онцолсон байна. Харин цаашид нэн тэргүүнд төрийн байгууллагын үйлчилгээг чирэгдэлгүй болгох, татварын таатай орчинг бүрдүүлэх, авлигалыг бууруулах зэрэг арга хэмжээг бодлогын төвшинд авч хэрэгжүүлэх шаардлагатай байна гэж үзжээ. Бизнесийн орчинд ЖДҮ эрхлэгчдийн энэ онд өгсөн үнэлгээ өнгөрсөн хоёр жилтэй харьцуулахад нэмэгдсэн байна. Тодруулбал, ЖДҮ эрхлэхэд макро эдийн засгийн болон хууль эрх зүй, зах зээлийн орчин харьцангуй боломжийн нөлөөг үзүүлж байна гэж дүгнэжээ.

Зээлийн хүүг бууруулах арга замуудыг хэлэлцэв.

Монголбанкнаас санаачлан “Зээлийн хүүг бууруулах арга замууд” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт эдийн засагч, судлаачид, банк болон банк бус санхүүгийн салбарын төлөөлөл оролцов. Дэлхийн банкны 2014 онд хийсэн судалгаагаар нийт 152 улс орноос 61 улсад нь зээлийн хүүний дээд хязгаар тогтоосон байдаг байна. Ингэхдээ санхүүгийн хэрэглэгчдийг хэт өндөр зээлийн хүүнээс хамгаалах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхийг зорьдог хэдий ч бодит байдалд энэхүү зорилт нь төдийлөн биелдэггүй болохыг олон судалгаа батлан харуулжээ. Тухайлбал, зээлийн хүүний дээд хязгаар тогтоосноор зээлийн зардлыг өсгөх, ил тод байдлыг бууруулах, зээлийн нийлүүлэлтийг багасгах, хууль бус зээлийн хэмжээг нэмэгдүүлэх зэрэг сөрөг үр дагавар үүсчээ. Олон улсад сайнаас илүү сөрөг үр дагавар давамгайлсан муу туршлагауд бэлээхэн байгаа тул зах зээлийн механизмд суурилсан зарчмаар зээлийн хүүг бууруулах нь илүү үр дүнд хүргэнэ гэдгийг оролцогчид онцолсон юм.





БАНКНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН СТАНДАРТЫГ ШИНЭ ТӨВШИНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БЭЛТГЭЛ АЖИЛ ЭХЭЛЧИХСЭН

Монголбанкны хяналт шалгалтын газрын захирал Н.Батсайхантай ярилцав.

ОУВС-ИЙН ӨРГӨТГӨСӨН САНХҮҮЖИЛТИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ ЯМАР ШАТАНД ЯВЖ БАЙНА ВЭ?

Монгол Улсын Засгийн газар, ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т гурван жилийн хугацааны туршид хамрагдахаар шийдвэрлэсэн. Тус хөтөлбөр нь 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрөөс эхэлсэн. Тус хөтөлбөрийн хэрэгжилтэд ОУВС улирал тутам үнэлгээ хийж байна. Тухайлбал, 8 дугаар сард ОУВС хөтөлбөрийн 5 дахь үнэлгээг хийж Захирлуудын Зөвлөлөөр 10 дугаар сарын 31-ний өдөр хэлэлцлээ. Тус үнэлгээгээр ажлын хэсэг манай улсын макро эдийн засгийн гүйцэтгэл эерэг байж, хөтөлбөрийн гол зорилтууд хангагдаж, эдийн

засаг сэргэж байгаа боловч цаашид хэрэгжүүлэх ажлууд байна гэж дүгнэсэн. Монгол Улс тус хөтөлбөрийн хүрээнд ойролцоогоор 5.5 тэрбум ам.долларын санхүүжилт авахаас 434.3 сая ам.доллар нь ОУВС-аас олгогдох зээл юм. Энэ оны эхнийн хагас жилийн байдлаар манай улс ОУВС-аас 184.5 сая ам.долларын санхүүжилтийг авсан байна.

ЮУНЫ ӨМНӨ АКТИВЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН БАНКНЫ СИСТЕМД ЯМАР НӨЛӨӨ ҮЗҮҮЛЭХЭЭР БАЙНА ВЭ?

Активын чанарын үнэлгээний үр дүнд банкны системийн хэмжээнд өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлага 2017 оны жилийн эцсийн ДНБ-д харьцуулахад 1.9 хувьтай

тэнцэхүйц хэмжээтэй гарсан нь Монголбанкнаас төсөөлж, урьдчилан таамаглаж байсан хэмжээтэй дүйцсэн гэж болно. Иймд Монголбанк банкуудаас 1 болон 9 дүгээр сард өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх төлөвлөгөө хүлээн авч, түүнийг хянаж баталгаажуулан биелэлтэд нь хяналт тавин ажиллаж байна. Банкуудаас 2020 он хүртэлх бизнес төлөвлөгөөг хүлээн авч үнэлсэн. Активын чанарын үнэлгээтэй уялдуулан 2018 оны эцэс гэхэд банкинд дутагдаж болзошгүй өөрийн хөрөнгийн дүнг тооцоолсон байгаа. Иймд Монголбанкнаас банкуудад өөрийн хөрөнгийг энэ оны эцэс гэхэд шаардлагатай төвшинд хүртэл нэмэгдүүлэх үүрэг өгсөн. Энэ оны эхний 9 сарын байдлаар системийн хэмжээнд 5 банк 140 тэрбум төгрөгөөр хувь

нийлүүлсэн хөрөнгөө нэмсэн байна. Мөн банкуудаас өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх хүсэлтүүд ирсэн. Монголбанк зөвшөөрөл олгох эсэхийг судалж байна. Тэгэхээр банкуудаас ирүүлсэн өөрийн хөрөнгийн төлөвлөгөөний биелэлтийг эцсийн байдлаар энэ оны эцэс гэхэд дүгнэх боломжтой.

Түүнчлэн Банкны хяналт шалгалтын дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх хүрээнд банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс 50.0 (тавин) тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 100.0 (зуун) тэрбум төгрөгөөр тогтоох шийдвэрийг гаргасан байдаг. Иймд банкууд мөн адил Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалын хүрээнд өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж байгаа гэж ойлгож болно.

Активын чанарын үнэлгээний үр дүнд банк тус бүрт зээлийн эрсдэлийн бодлого, холбогдох журам зааврыг хэрхэн сайжруулах тал дээр зөвлөмж өгсөн байгаа. Тус зөвлөмжийн биелэлтийг банкуудад хийгддэг иж бүрэн шалгалтын хүрээнд газар дээр нь очиж шалгаж байна.

ӨӨРИЙН ХӨРӨНГӨ НЬ БАНКИНД ЯМАР АЧ ХОЛБОГДОЛТОЙ ВЭ?

Банкны хувь нийлүүлсэн хөрөнгө нь банкны харилцагч, хадгаламж эзэмшигчдийн банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, тэдгээрийн хөрөнгийг хамгаалах, банк алдагдал хүлээх тохиолдолд алдагдлын тодорхой хэсгийг нөхөх гол үүрэгтэй байдаг. Банкны хувь нийлүүлсэн

хөрөнгийн зохистой хэмжээ нь улс орны банк, санхүүгийн тогтолцооны найдвартай, хэвийн байдлыг хангахад гол нөлөө үзүүлдэг бөгөөд банкны үйл ажиллагааны алдагдлыг шингээж чадахуйц хэмжээний хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байснаар банкны актив чанаргүй болох үед банкиг төлбөрийн чадваргүй болохоос тодорхой хэмжээгээр урьдчилан сэргийлж чаддаг.

ОУВС-ИЙН "ӨРГӨТГӨСӨН САНХҮҮЖИЛТИЙН ХӨТӨЛБӨР"-Т ХАМРАГДСАНААР БАНКНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН САЙЖИРСАН УУ?

Банкны салбарын тулгуур хуулиудын нэг болох Банкны тухай хууль хамгийн сүүлд 2010 онд шинэчлэгдэж байсан. ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд банкны салбарын эрх зүйн зохицуулалт, Монголбанкнаас банкинд тавих үйл ажиллагааны хууль зүйн орчинг олон улсын зарчим, хэм хэмжээнд тулгуурлан боловсронгуй болгох бодлого баримталж, хэрэгжүүлэхээр болсон. Иймд 2018 оны эхэнд Банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Тус хуулийг баталснаар хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагад тавих шалгуурыг илүү тодорхой болгож, нарийвчлан зохицуулсан. Мөн банк ба банкны холбогдох этгээдийн харилцааны хязгаарлалтыг сайжруулсан, банкинд авах албадлагын арга хэмжээг зөрчил гарсан буюу банкны санхүүгийн байдал муудсан, зохистой харьцааны шалгуур үзүүлэлт алдагдсан,

төлбөрийн чадваргүй болсны дараа авах бус харин уг асуудал үүсэхээс өмнө буюу урьдчилан сэргийлэх байдлаар авах боломжтой байхаар эрх зүйн орчинг сайжруулсан.

БАНКНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬ ӨНГӨРСӨН ЗУН БАТЛАГДСАН. ТУС ХУУЛЬ БАНКНЫ САЛБАРТ ЯМАР ЭЭРЭГ НӨЛӨӨ ҮЗҮҮЛЭХ БОЛ?

Юуны өмнө энэ хуулийг яагаад батлуулах болсон шаардлагыг товчхон тайлбарлах нь зүйтэй байх. Бид энэ ярилцлагыг активын чанарын үнэлгээнээс эхэлсэн. Активын чанарын үнэлгээгээр банкуудын активыг үнэлсэн бөгөөд үнэлгээний үр дүнд хэрэв банкууд зохистой байдлаар активын эрсдэлийн санг байгуулаагүй бол нэмж эрсдэлийн сан байгуулахаар болсон. Активын эрсдэлийн сан нь зардлаар байгуулагддаг тул банкуудад өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлага үүссэн. Иймд банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах, ирээдүйд төрөөс гарч болзошгүй их хэмжээний зардлыг бууруулах зорилгоор ОУВС-тай тохиролцон активын чанарын үнэлгээ, эрсдэлийн сорилын үр дүнд өөрийн хөрөнгийн дутагдалтай гарсан банкны салбарын нөлөө бүхий банкуудыг дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагааны зарчмыг тодорхойлж, эдгээр зарчмыг зохицуулсан хууль, эрх зүйн баримт бичгийг батлуулах шаардлага бий болсон



юм. Иймд тус хууль батлагдсанаар банк өөрийн хөрөнгийн дутагдлыг төрөөс бусад хөрөнгө оруулагчдаас бүрдүүлэх боломжгүй тохиолдолд урт болон дунд хугацаанд банкны хэвийн үйл ажиллагааг явуулах, тогтвортой, ашигтай ажиллах боломжтой банкны системийн нөлөө бүхий банкны өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлж, төрөөс оруулсан хөрөнгийг үр ашигтай удирдан харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах, төрөөс оруулсан хөрөнгийг төсөвт буцаан төвлөрүүлэх замаар улс орны эдийн засаг, санхүүгийн салбарыг тогтворжуулах зорилгоор улсын төсвөөс гарч болзошгүй зардал буурах ач холбогдолтой.

**СИСТЕМИЙН ХЭМЖЭЭНД
ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙГ
БУУРУУЛАХ ЯМАР АРГА
ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЖ**

БАЙНА ВЭ?

Манай улсын банкны системийн хувьд 2018 он их чухал жил байлаа. Бид активын чанарын үнэлгээгээр банкуудын “эрүүл мэнд”-ийг оношилж, цаашид авах арга хэмжээгээ илүү тодорхой болгосон гэж дүгнэж болно. Энэ оны төгсгөлд банкууд шаардлагатай өөрийн хөрөнгийг нэмэгдүүлнэ гэсэн хүлээлттэй байна. Монголбанкнаас банкуудад хийх хяналт шалгалтын үйл ажиллагаа нь “гүйцэтгэлд суурилсан” зарчмаас “эрсдэлд суурилсан” хэлбэрт шилжиж байгаа тул санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой гэж дүгнэж байна. Мөн өнгөрсөн 6 дугаар сард Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Хадгаламжийн даатгалын корпорацитай хамтран “Чанаргүй активыг бууруулах стратегийн баримт бичиг”-ийг баталсан. Чанаргүй зээл нь банкны

актив хөрөнгийг бууруулах, банкны ашигт ажиллагаа, өөрийн хөрөнгийг хорогдуулан банкны системийн төлбөрийн чадварт шууд нөлөөлөх үр дагавартай тул эрсдэлийг нэмэгдүүлдэг. Мөн шинээр зээл олголтыг зогсоох гол хүчин зүйлүүдийн нэг болдог. Банкны системийн хувьд 9 дүгээр сарын 30-ны байдлаар чанаргүй зээлийг нийт активд харьцуулахад 5.1 хувьтай байна. Тус стратеги нь ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтын хөтөлбөр”-ийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг юм. Иймд тус стратегийн хүрээнд хууль эрх зүйн орчинг сайжруулах зорилгоор Арбитрын тухай хууль, Дампуурлын тухай хууль, Компанийн тухай хууль, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Татварын тухай хууль болон бусад хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт орно. Мөн барьцаа хөрөнгийг шүүхийн бус замаар худалдан борлуулах эрх зүйн

орчныг сайжруулах тал дээр ч ажиллаж байна.

ЦААШИД БАНКНЫ СИСТЕМД ЯМАР ӨӨРЧЛӨЛТ ОРОХ БОЛ?

Арилжааны банкууд Монголбанк, Сангийн яамны хамтарсан тушаалаар батлагдсан Банкны нягтлан бодох бүртгэлийн зааврын дагуу санхүүгийн тайлангаа гаргадаг, тус зааврыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад бүрэн нийцүүлэн боловсруулсан. Банкууд 2020 оноос санхүүгийн хэрэглүүрийг хүлээн зөвшөөрөх, бүртгэх СТОУС 9-ийг мөрдөж эхэлнэ. Санхүүгийн хэрэглүүр гэдэг нь нэг аж ахуйн нэгжийн хувьд санхүүгийн хөрөнгийг, нөгөө аж ахуйн нэгжийн хувьд санхүүгийн өр төлбөрийг эсвэл өмчийн хэрэглүүрийг үүсгэж байдаг аливаа гэрээ юм. Нягтлан бодох бүртгэлийн олон улсын 39 дүгээр стандартын дагуу санхүүгийн хөрөнгийг хатуу тогтоосон тодорхойлолтын дагуу ангилдаг байсан бол СТОУС 9 нь бизнесийн загвар, мөнгөн урсгалын мөн чанарт үндэслэн ангилна гэсэн үг.

БАНКНЫ ӨӨРИЙН ХӨРӨНГӨД ТАВИХ ШААРДЛАГА ӨӨРЧЛӨГДӨХ ҮҮ.

Банкны хяналт шалгалтын дунд хугацааны стратегийн хүрээнд бид Базел II баримт бичгийн стандартын 2 дахь хэсгийг /Basel II, Pillar 2/ хэрэгжүүлж эхэлнэ. Тус стандартын 1 дэх хэсэг /Pillar 1/ нь өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой хэмжээг тогтоосон бол 2 дахь хэсэг буюу Pillar 2-ын хүрээнд банкуудад

түүний үйл ажиллагаанаас нь үүсэх эрсдэлийг даах хэмжээний өөрийн хөрөнгөтэй байх шаардлагыг тавьдаг ба хэрэв энэ шаардлагыг хангаж чадахгүй бол зохицуулагч байгууллагаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна. Өөрөөр хэлбэл, нэг дүгээрт, банкууд өөрийн эрсдэлийн төвшинд тохируулан өөрийн хөрөнгийн шаардлагатай хэмжээг тогтоох аргачлалтай байна, мөн өөрийн хөрөнгийг зохистой хэмжээнд байлгах бодлого боловсруулна, хоёрдугаарт, Монголбанкнаас банкны дотоод бодлого, аргачлалыг нь хянаж, зохистой харьцааг хангаж байгаа эсэхэд хяналт тавина, шаардлагатай тохиолдолд хяналт шалгалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Гуравдугаарт, банкуудаас нийт өөрийн хөрөнгийн үзүүлэлтийн доод шаардлагыг хангахаас гадна нэмэлт шаардлагыг хангахыг шаардана, дөрөв дүгээрт, хэрэв банкны өөрийн хөрөнгийн хэмжээ нь тогтоосон хэмжээнээс буурах нөхцөл байдал үүсвэл өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлага тавина, хэрэв банк өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж чадахгүй байвал шаардлагатай хяналт шалгалтын арга хэмжээг авна гэсэг үг. Иймд Монголбанк, арилжааны банкууд цаашид илүү нягт холбоотой хамтран ажиллаж хяналт шалгалтын шинэ төвшинд хүрнэ гэж үзэж байна. Төв банкны хяналт шалгалтын үйл ажиллагаа нь Базел II-ийн стандартыг бүрэн хэрэгжүүлж чадвал гадаадын хөрөнгө оруулагчдын итгэл нэмэгдэж, хөрөнгө оруулах таатай нөхцөл бүрдэх юм.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ДҮРЭМ, ЖУРАМД ЯМАР ӨӨРЧЛӨЛТ ОРОХ ВЭ?

Дээр дурдсан ажлуудтай холбогдуулан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ыг олон улсын сайн туршлагад нийцүүлэн илүү боловсронгуй болгоно. Мөн “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д өөрчлөлт орно. Одоогийн мөрдөж байгаа журамд зарим салбарын зээлийн эрсдэлийн жинг хөнгөлөлттэйгөөр тооцож байгааг зогсоож, олон улсын жишгээр тогтооно. Тус өөрчлөлтөөс үүдэн банкны эрсдэлээр жигнэсэн активын дүн нэмэгдэж өөрийн хөрөнгийн зохистой харьцаанд нөлөөлнө. Иймд банкууд холбогдох дүрэм, журамд орох өөрчлөлтийг ирэх онуудын бизнес төлөвлөгөөний тооцоололд авч үзэж, бусад үйл ажиллагаандаа анхаарах нь зүйтэй.

Ярилцсанд баярлалаа.



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэл

НЭГ. Мөнгөний бодлогын зорилтын хүрээнд:

8%

Инфляци

Инфляцийг 2019-2020 онд жилийн **8 хувь**, дунд хугацаанд **6 хувь** орчимд тогтворжуулна.

Стратеги

- Хүлээлтийг удирдах, эрэлтийн шинжтэй инфляцийг зохистой түвшинд барьж, худалдан авах чадварыг нэмэгдүүлнэ;
- Ирээдүйг харсан мөнгөний бодлогын шийдвэр гаргана;
- Нийлүүлэлтийн ба нэг удаагийн инфляцид мөнгөний бодлогоор нөлөөлөхгүй;
- Засгийн газартай хамтарч, макро эдийн засгийн бодлогын үр нөлөөг дээшлүүлнэ.



Гадаад валютын нөөц

Эдийн засгийн **дархлааг дэмжих** хүрээнд гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлнэ.

Стратеги

- Мөчлөг сөрсөн мөнгөний болон макро зохистой бодлого хэрэгжүүлнэ;
- Төгрөгийн ханш эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэй, уян хатан тогтох зарчмыг баримтална;
- Ханшийн богино хугацааны огцом савлагаанаас сэргийлж санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлнэ.



Макро зохистой бодлого

Макро зохистой бодлогын хэрэгслүүдийг **мөнгөний бодлоготой хослуулан** хэрэгжүүлнэ.

Стратеги

- Мөчлөг дагасан зээлийн огцом тэлэлтээс сэргийлэх, системийн эрсдэлийг бууруулах мөчлөг сөрсөн макро зохистой бодлогын хэрэгслүүдийг хэрэгжүүлнэ;
- Бодлогын урьдач болон дараах шинжилгээ хийх загвар, санхүүгийн салбарын эмзэг байдлыг тодорхойлох шинжилгээний арга зүйг боловсронгуй болгоно;
- Макро зохистой бодлогын стратегийг боловсронгуй болгоно.



Олон нийттэй харилцах

Төв банкны олон нийттэй харилцах үйл ажиллагааг сайжруулж, **бодлогын нөлөөг дээшлүүлнэ.**

Стратеги

- Олон нийтэд хүргэх мэдээллийн агуулгыг хөгжүүлнэ;
- Мэдээлэл түгээх үр дүнтэй сувгуудыг ашиглана;
- Зорилтот бүлгүүдийг оновчтой ангилж, тус бүрийн хэрэгцээ, шаардлагад нь тохирсон арга хэлбэрээр мэдлэг, мэдээллийг түгээнэ.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРОО

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРОО 11 ДҮГЭЭР САРД ЭЭЛЖИТ БУСААР ХУРАЛДАЖ, БОДЛОГЫН ХОРООНЫ ХҮҮГ 1 НЭГЖ ХУВИАР ӨСГӨЖ, 11 ХУВЬД ХҮРГЭХ ШИЙДВЭР ГАРГАЛАА. УГ ШИЙДВЭРИЙН ТАЛААР ЭДИЙН ЗАСАГЧ, СУДЛААЧИД ЯМАР БАЙР СУУРЬТАЙ БАЙГААГ ХҮРГЭЖ БАЙНА.



ЭДИЙН ЗАСАГЧ **Ц.БАТСҮХ**

Бодлогын хүүг өсгөснөөрөө мөнгөний нийлүүлэлтийг хумьж, инфляци хөөрөгдөх боломжийг хашиж өгч байгаа. Үүнд нэг сөрөг тал байгаа нь юу гэхээр зээлийн хүүнд тодорхой хэмжээний дарамт авчрах байх. Судалгаагаар бодлогын хүүгийн 1 нэгж хувийн өсөлт нь зээлийн хүүд 0.3 хувийн өсөлт авчрах нөлөөлөлтэй байна. Нөгөөтэйгүүр бодлогын хүүг өсгөх шийдвэр нь эдийн засгийн идэвхжил харьцангуй суларч байгаа үед таарч байгаа. Тийм учраас зээлийн хүүтэй холбоотой сөрөг тал харьцангуй бага, эерэг тал нь илүү өндөр байх болов уу. 2018 он их эерэг байсан. Бид энэ үеийг ашиглаж, мөнгөний бодлогоо сулруулж, бизнес эрхлэгчдээ дэмжихийг зорьсон. Гэвч 2019 онд нөхцөл байдал хүнд байх нь. Тийм учраас цаашид ч бас мөнгөний бодлого чангарах байх. Яагаад гэвэл сангийн бодлого талдаа нэлээд тэлсэн байна. Энэ нь цаашдаа инфляцийг хөөрөгдөх үндсэн нөхцөл болно. Төв банк үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлыг хангах үүднээс мөнгөний бодлогыг чангаруулах чиглэлд л арга хэмжээ авах болов уу гэж харж байна.



ЭДИЙН ЗАСАГЧ **Ж.ДЭЛГЭРСАЙХАН**

Эдийн засаг сайжирснаар зээлийн хүү буурдаг нь Монголд ч бас батлагдсан. Энэ нь 2012 оны хүүгийн төвшин болон 2016 оны хүүг өнөөгийн хүүтэй харьцуулсан харьцаа харуулна. 2016 оноос хойш зээлийн хүү болон хадгаламжийн хүү нэлээд буурсан. Тэгэхээр мөнгөний бодлогын хүүг өсгөснөөрөө шууд зээлийн хүүг буцаагаад өсгөх хандлага руу орж байна гэж би бодохгүй байна. Зээлийн хүү өндөр байгаа шалтгаан нөгөө талдаа улс төр, эдийн засаг, нийгмийн орчны тогтворгүй байдал, ялангуяа эдийн засаг төрөлжиж чадаагүй гэх зэрэг эрсдэлийн төвшин өндөр байгаатай холбоотой. Тэгэхээр Төв банк бодлогын хүүг өсгөсөн нь ирээдүйд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах зорилготой гэж харж байна. Эрсдэлийг бууруулж байгаа учраас зээлийн хүүг шууд хүчтэй нэмэгдүүлэх нөлөөллийг авчрахгүй. Харин эдийн засаг дахь хүлээлтийг харьцангуй болгоомжилсон байдал руу оруулснаар эрсдэлийг бууруулж байгаа юм.

МОНГОЛБАНКНЫ ШИЙДВЭРИЙН ТАЛААР ХЭН ЮУ ХЭЛЭВ?



ЭДИЙН ЗАСАГЧ Ц.МӨНХБАЯР

Бодлогын хүүг бууруулсан нь бизнесийн зээл олголтыг нэмэгдүүлж, шууд нөлөөлж байсан бол энэ удаагийн шийдвэр нь шууд бусаар нөлөөлнө. Өөрөөр хэлбэл, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалснаар бизнес эрхлэгчдийг дэмжиж байгаа. Ийм орчинд бодлогын шийдвэр нь бизнес эрхлэгчдийг дэмжиж байна гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл, тэнцвэрийг хадгалснаар бизнест эергээр нөлөөлнө. Гуравдугаар сард бодлогын хүүг бууруулснаас хойш бизнесийн зээлийн жилийн өсөлтийн хувь сүүлийн хоёр улирал дарааллан өссөн байгаа. Тэгэхээр 11 хувийн бодлогын хүү нь бизнесийн зээлийн өсөлтийн энэхүү төлөвийг хадгална гэсэн үг. Ер нь макро эдийн засгийн өсөлт бол хэт их өсөлт биш эдийн засгийн тэнцвэрийг хадгалах, тогтвортой байдлыг хангах нь хамгийн чухал. Тийм ч учраас Мөнгөний бодлогын хороо бодлогын хүүг өсгөх шийдвэр гаргасан.



ЭДИЙН ЗАСАГЧ Г.МӨНХ-ЭРДЭНЭ

Монголбанк 2016 онд бодлогын хүүгээ 15 хувьд хүргэж, түүхэн дээд хэмжээ тогтоож байсан. Би тухайн үед Монголбанк бодлогын хүүгээ хожимдож өсгөлөө гэж харж байсан. Бодлогын хүүг өсгөхийн өмнө ханш үндсэндээ алдагдсан байсан. Тэрний дараа бодлогын хүүг огцом өсгөж, зах зээл дээр шокийн нөлөө үзүүлсэн. Үүний дараа интервенц маш сайн хийгдсэн байдаг. Харин энэ удаад маш хурдан хөдөлж байна. 12 дугаар сарын 17-нд хуралдах байсан хурлаа наашлуулаад, шийдвэр гаргаж байна. Тэгэхээр Монголбанк зах зээлээ илүү хурдан мэдэрч, ирээдүйн нөхцөл байдлаа илүү урт хугацаанд харж байх шиг байна. Үүний илрэл нь Монголбанкны бодлогын шийдвэр болж байна. Ямартай ч Монголбанк ирээдүйд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан харж, богино хугацаанд арга хэмжээ авч байгаа нь сайн хэрэг. Үүний дараа валютын дуудлага худалдаагаар зах зээлд доллар нийлүүлж эхэлбэл, ханшид хосолсон цохилт өгч, тогтвортой байлгах нөхцөлийг бүрдүүлэх болов уу.



ЦААСАН МӨНГӨН ТЭМДЭГТ (1287 ОН)

Урт: 28 см, Өргөн: 23.5 см

Цаасан мөнгийг Хубилай хааны зарлигаар Юань улсад гүйлгээнд хэрэглэж эхэлсэн. Түүний хаанчлалын оны цолоор Жи Юань (1264-1294 он) хэмээн нэрлэжээ.

Модны холтос, зарим ургамлын навч зэргийг хольж тусгай аргаар боловсруулсан цаасан дээр барласан мөнгө. Юань улсын энэхүү мөнгөн тэмдэгт нь “1 кун” буюу “1 хэлхээ” хэмээн нэрлэгдэнэ. “Хэлхээ” гэдэг нь 100 ширхэг зоосон мөнгөний хэлхээг хэлэх бөгөөд цаасан мөнгөн дээрх “1 хэлхээ” нь 100 ширхэг зоостой тэнцэх нэрлэсэн үнэтэй гэсэн утгыг агуулна.

Мөнгөн тэмдэгт дээрх дийлэнх бичээсийг хятад ханзаар бичсэн. Тэмдэгтийн баруун, зүүн талд “Бүх нутаг дэвсгэрт гүйлгээний эрхтэй” гэсэн үгийг дөрвөлжин бичгээр бичиж, их хааны сангийн тамга даржээ.

Тэмдэгтийн доод хэсэгт “Мөнгөн тэмдэгтийг хуурамчаар үйлдвэл цаазын ялтай. Гэмт этгээдийг мэдээлсэн хүнийг мөнгөөр шагнана. Энэхүү цаасан мөнгө нь хааны албанаас баталсан өндөр эрхтэй бөгөөд бүх орон нутагт хугацаагүй гүйнэ” гэсэн утга бүхий хятад бичээстэй.





“УЛААНБААТАРЫН ЗӨВШИЛЦӨЛ”-ИЙГ ДЭМЖИХ НЬ

С.ДЭМБЭРЭЛ УИХ-ын гишүүн асан, эдийн засагч

Эдийн засагч, судлаач Н.Баяртсайхан, Д.Ган-Очир нар “Эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжлийг бий болгох асуудалд” нэртэй судалгааны томоохон өгүүлэл хэвлүүлсэн байна. Зах зээлийн эдийн засагтай улс орнуудад Төв банк нь тухайн улсын эдийн засгийн гол тинктанк байдгийн адил Монголбанкны эдийн засагчид, тэр тусмаа Ерөнхийлөгч нь өсөлт, хөгжлийн стратегийн асуудлаар ийм бодлогын санал дэвшүүлж буйг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Энэ өгүүлэлд сүүлийн 27 жилийн турш Монгол Улсын хөгжил, өсөлт яаж хэрэгжиж ирсэн, энэ хугацааны төрийн бодлогын алдаа, оноо, цаашдын сургамж төдийгүй дэлхий дээр бий болсон хөгжил, өсөлтийн онолын урсгал, үзэл номлол, үзэл баримтлалуудыг харьцуулан судалсны үндсэн дээр Монгол Улсын хувьд цаашдаа баримталбал зохих хөгжил, өсөлтийн загвар ямар байж болох талаар “Улаанбаатарын зөвшилцөл” хэмээх нэртэй үзэл баримтлалыг дэвшүүлэн тавьсан байна. Анх “Вашингтоны зөвшилцөл” нэртэйгээр олон улсын хэмжээнд гарсан дэлхийн хөгжил, өсөлтийн үзэл баримтлалаас хойш эдүгээ улам боловсронгуй болон баяжин шинэчлэгдсээр буй өсөлт, хөгжлийн үзэл номлолыг Монголын хөрсөнд бодитой шингээх, нутагшуулах чиглэлээр өнгөрсөн 27 жил Монгол Улс олон төрлийн шинэчлэлийн бодлого хэрэгжүүлсэн. Алдсан ч бий, оносон ч бий. Гэхдээ Монгол Улсын хөгжил, өсөлтийн стратеги нь цаашдаа өнгөрсөн 27 жилийн туршлагаа задлан шинжилж, нэгтгэн дүгнэсний үр дүнд гарч ирсэн, нийгмийн зөвшилцлийн

үр дүнгийн баримт бичиг байх учиртай бөгөөд яг энэ өнцгөөс нь хөгжил, өсөлтийн асуудалд хандаж “Улаанбаатарын зөвшилцөл” хэмээх үзэл баримтлалыг гаргаж өргөн олны хэлэлцүүлгийг санаачилж байгаа эдийн засагчдад талархаж байна. Тиймээс энэ санаачилгад нэгдэн орж дэмжиж байгаагийн хувьд зарим санааг хөндсөн болно. Өнгөрсөн 27 жилд Вашингтоны зөвшилцлийн үзэл санаа, агуулга хөгжиж буй болон зүгширч буй зах зээлийн эдийн засагтай улс орнууд болон шилжилт хийсэн бүх улсын хувьд янз бүрийн хэлбэрээр хэрэгжиж ирсэн ба Монгол улсын хувьд ч 1990 оноос эхлэн энэхүү зөвшилцлийн үзэл санаа, утга агуулга нь Засгийн газар бүрийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдаж ирсэн. Харин хэрэгжилтийн хувьд янз бүр байсан. Тиймээс дэлхий дээр ч Монгол Улсын хувьд ч Вашингтоны зөвшилцөл мөхөөгүй, үзэл санаа, агуулга нь баяжсаар иржээ. Дэлхийн улс орнуудад хэрэгжиж ирсэн өсөлтийн стратегийн ерөнхий оношийн хувьд авч үзвэл доорх зүйлүүдийг онцолж ирсэн байдаг.

Онцолж ирсэн зүйлүүд:

1. Мэргэшил, сургалтын болон тухайн улсын хүмүүн капиталын суурийг сайжруулах
2. Макро эдийн засгийн бодлого, түүний дотор төсөв, мөнгөний бодлогыг сайжруулах
3. Гадаад харилцаа, ГХО-ын нээлттэй байдлыг нэмэгдүүлэх
4. Хэт өндөр татвар, бизнес эрхлэлтийн өртөг хэт их нэмэгдэхээс зайлсхийх
5. Эдийн засгийг өөрчлөн байгуулах үйлдвэржилтийн бодлого, өндөр бүтээмж

бүхий шинэ үйлдвэрлэлийг богино хугацаанд хөгжүүлэх

6. Авлигатай тэмцэх, өмчийн эрхийг бэхжүүлэх
7. Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх

Эдгээрт суурилсан, онцолсон өсөлтийн стратеги улс орнуудад хийж ирсэн ч иймэрхүү “угаах юмны жагсаалт” маягийн хандлага нь тэр бүр амжилттай хэрэгждэггүй нь өнгөрсөн 27 жилийн Монголын төдийгүй бусад хөгжиж буй орнуудын туршлагаас харагддаг бөгөөд ерөнхийдөө ижил оноштой эдийн засгуудад өөр өөр байдлаар хэрэгжиж ирсэн байдалд онолын болон бодлогын практикийн төвшинд олон янзын дүгнэлт хийсээр иржээ. Тиймээс хамгийн их саад бэрхшээл учруулж буй хэсгүүдэд реформыг чиглүүлж, жагсаалтыг багасгах, тэргүүлчлэх хэрэгтэй, энэ нь өсөлтийн ямар загвар сонгохоос хамаарна гэж нэг хэсэг эдийн засагчид үздэг. “Шинэ сонгодог онолын” загвар баримталдаг эдийн засагчид биет болон хүмүүний капитал, түүнд саад болж буй зүйлүүдийн талаар онцолдог бол “эндоген” өсөлтийн загвар баримтлагчид (өөрөөр хэлбэл ГШХО, шинэ технологид хөрөнгө оруулах гэх мэт) зах зээлийн өрсөлдөөн, инновацийн тааламжтай орчныг бүрдүүлэх нь чухал гэж үздэг. Институтүүдийн чанар хамгийн чухал гэж үздэг эдийн засгийн загварыг баримтлагчид өмчийн эрх, гэрээний гүйцэтгэл гэх мэтийг онцолдог бол “dual economy” загварыг баримтлагчид уламжлалт эдийн засгаас орчин үеийн эдийн засаг руу очих шилжилт, ийм үеийн бүтцийн өөрчлөлт, шилжилтийн нөхцөлүүдийг илүү авч үздэг. Эдгээр

загвар бүр өсөлтийн асуудлыг өөр өөрийн өнцгөөс харж өсөлтийн стратегийг хэрэгжүүлэх, тэргүүлэх чиглэлүүдээ өөр өөрсдийнхөөрөө гаргаж тавьдаг байна. "Улаанбаатарын зөвшилцөл"-ийн үзэл санаа, үзэл баримтлалыг дэвшүүлэн тавьж буй нь өөрөө дэвшил бөгөөд хөгжлөө, эдийн засгийн өсөлтөө төсөөлж харсан, цэгцтэй алсын хараа, өсөлтийн стратегийг дэлхийн туршлага (эндоген) Монголын өөрийн онцлог, өсөлтийн түүхэн тоо баримт, дүн шинжилгээ дээр суурилан гаргасан (экзоген) нухацтай үзэл санаа тул нэн тэргүүнд дэмжих нь зүйтэй ба харин уг "зөвшилцөл"-ийн доторх агуулга, тэргүүлчлэл, утга санааг сайтар хэлэлцэж баяжуулах нь "зөвшилцөл" гэж нэрлэсний гол утга учир болно.

Тэр тусмаа:

- а. Экспортын бүтэц нь уул уурхайн бүтээгдэхүүн дээр суурилдаг өрөөсгөл;
- б. Хөгжил, өсөлтийн стратегийн гол арга замыг уул уурхай, дэд бүтцийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх гэж үздэг;
- в. Эдийн засгийн бүтэц нь дуаль эдийн засгийн шинж тэмдгүүдийг агуулсаар байгаа буюу уламжлалт ба орчин үеийн эдийн засаг зэрэгцэн оршсоор буй эдийн засгийн бүтэцтэй;
- г. Хүн ам цөөхөн, хүн ам зүйн бүтэц нь залуу ч хүмүүн капиталын үр ашиг, бүтээмж доогуур;
- д. Дэлхийн хамгийн том хоёр зах зээлийн дунд байршдаг ч уг хоёр зах зээл рүү идэвхтэй нэвтрэн орох экспортын салаалалтын (дивер-сификац) стратеги боловсруулж хэрэгжүүлэхэд дутуу ач холбогдол өгч ирсэн;
- е. Үндэсний хуримтлалын төвшин доогуур, компаниудын олонх нь жижиг зах зээлд тулгуурлан үйл ажиллагаа явуулдаг тул өсөж томрох хязгаарлалттай, ядуурлын төвшин өндөр, архагшсан, нийгмийн давхраажилтын бүтцэд дундаж давхарга голлож чадаагүй, ядуу болон дунджаас доош давхарга голлосон бүтэцтэй;
- ё. Хуулийн засаглалын хэрэгжилт, институцүүдийн чанар доогуур тул хөгжил, өсөлтийн стратегийн үйл явцын удирдлага нь дээрх зүйлүүдийг багтаасан иж бүрэн бус, тунхаглалын шинж чанартай, эндоген болон экзоген хүчин зүйлүүдийн зохистой хослолыг бий болгоогүй улсад энэхүү зөвшилцөл нэг чухал ач холбогдолтой юм.

"Улаанбаатарын зөвшилцөл" бол агуулга талаасаа дэлхийн эдийн засагчид, олон улсын байгууллагуудаас санал болгосон үзэл номлол, үзэл баримтлал, бодлого, стратегийн баримт бичгүүдээс түүвэрлэж авсан зүйлүүдийн цуглуулга биш, харин эдгээр баримт бичгийн глобал болон тухайн улс орны төвшинд хэрэгжиж ирсэн байдал, туршлагыг нэгтгэн дүгнэсэн, Монгол улсын онцлогийг харгалзсан судалгаа шинжилгээний үр дүнгийн баримт бичиг тул түүний агуулгатай эхлээд танилцах нь зүйтэй юм.

Дээрх хоёр эдийн засагчийн санал болгож буй "Улаанбаатарын зөвшилцөл" доорх агуулгатай байна.

- Засаглал, институцийг сайжруулж, чанарыг бэхжүүлэх;
- Авлигын эсрэг тууштай тэмцэх
- Хувийн хөрөнгө оруулалтыг даллах дэд бүтэц, хүмүүн капиталд хөрөнгө оруулалт

хийх, технологийн дэвшлийг нэвтрүүлэн ашиглах чадавхийг бий болгох;

- Хүртээмжтэй өсөлтийг бий болгох;
- Орлогын тэгш бус байдал хэт өсөхөөс сэргийлэх;
- Хямралаас зайлсхийж байх, бодит эдийн засаг, инфляцийг тогтворжуулах;
- Төсвийн сахилга батыг хангах, үндэсний хуримтлалыг нэмэгдүүлэх; (жишээ нь улсын баялгийн санг анивжуулах)
- Улсын өрийг хэт өндөр буюу тогтворгүй төвшинд хүрэхээс сэргийлэх (тогтворгүй өр нь өсөлтийг хэдэн арван жилээр ч хойш татна);
- Эдийн засгийн дархлааг хангах хэмжээнд гадаад валютын нөөцийг хуримтлуулах, эдийн засгийн өрсөлдөх чадварыг бүрдүүлсэн валютын ханштай байх;
- Хүчтэй санхүүгийн салбарыг бий болгох, санхүүгийн зах зээлийг зохистой төвшинд хүргэх (либералчлах);
- Аж үйлдвэржилт рүү хөтлөх, гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай компаниудыг бий болгож, дэмжих;
- Иргэний нийгмийн үйлчилгээг тэгш хүртэх, бүс нутгууд тэгш хөгжих боломжийг бүрдүүлэх;
- Байгаль орчны бохирдлыг арилгах, цаг уурын өөрчлөлтийн эсрэг арга хэмжээнд нэгдэх;
- Төрийн сайн бодлогыг тааруу бодлогоос нь ялгахад туслах мэтгэлцээн өрнөх орчин, тогтолцоо (тинк-танк, судалгааны болон хэвлэл мэдээллийн байгууллага);

МОНГОЛБАНК

Монголбанк юу хийдэг вэ?

“Төв банк/Монголбанк/-ны тухай хуульд зааснаар”
өөрийн зорилтыг биелүүлэхийн тулд дараах
чиглэлээр үйл ажиллагаа эрхэлнэ.

Мөнгөний бодлого боловсруулж, хэрэгжүүлэх



Монголбанк төрийн мөнгөний бодлогыг боловсруулж, хэрэгжүүлнэ.



Монголбанк дараагийн жилд баримтлах төрийн мөнгөний бодлогыг боловсруулж, жил бүрийн 10 дугаар сарын 1-ний дотор Улсын Их Хуралд өргөн барина.



Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, зохицуулах




Мөнгөн тэмдэгт үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, түүний нөөцийг бий болгох, хүчин төгөлдөр эсэхийг тодорхойлох, гэмтэж муудсаныг солих, устгах ажлыг эрхлэн зохион байгуулна.



Гэмтэж муудсан мөнгөн тэмдэгт солих журмыг Монголбанк тогтооно.

Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх



Төрийн сангийн нэгдсэн дансыг Сангийн сайдын хүсэлтээр өөр дээрээ байршуулж, гүйлгээг хийнэ.



Засгийн газрын хүсэлтээр Засгийн газрын үнэт цаасыг бусад этгээдэд зуучлан борлуулна.



Хууль тогтоомжид нийцсэн зуучлалын бусад үйл ажиллагаа эрхэлнэ.



Банк болон хуульд тусгайлан заасан этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих



Банкны тогтолцооны найдвартай байдлыг бэхжүүлэх зорилгоор банк байгуулах зөвшөөрөл банкинд олгоно.



Үйл ажиллагааг нь зохицуулахтай холбогдсон дүрэм, журам шийдвэр гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.



Хадгаламжийн даатгалын корпорацийн үйл ажиллагаанд хяналт тавина.

Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулах



Банк хоорондын төлбөр тооцоог Монголбанкин дахь тухайн банкны харилцах дансаар дамжуулан гүйцэтгэнэ.



Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагаанд холбогдсон харилцааг Үндэсний төлбөрийн системийн тухай хуулиар зохицуулна.



Гадаад валютын улсын нөөцийг эзэмших, удирдах



Монголбанк эзэмшин, удирдаж байгаа гадаад валютын улсын нөөцийн гадаад төлбөрийг түргэн гүйцэтгэх чадвар, найдвартай байдлыг хангана.



Монголбанк чөлөөтэй хөрвөдөг гадаад валют, түүнтэй адилтгах хэрэгслийг төгрөгөөр худалдах, худалдаж авахдаа төгрөгийн тогтвортой байдлыг хангана.

Банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах



Зохистой харьцааг хангуулах хяналт шалгалтыг хэрэглэгчийг хамгаалах хяналттай хослуулна.



Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах "Их 20"-ын 11 зарчмыг нэвтрүүлнэ.



Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.



Макро зохистой бодлого хэрэгжүүлэх



Мөнгөний бодлогын хэрэгжилт болон банк, санхүүгийн эрсдэлийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх зорилгоор тус бодлогыг боловсруулна.



Макро зохистой бодлогыг заавал байлгах нөөц зэрэг хэрэгслүүдээс ашиглан хэрэгжүүлнэ.



Ц.ГАРЬД: МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨР ТООЦОО ОЛОН УЛСЫН ЖИШИГТ ХҮРСЭН

Монголбанкнаас Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Төлбөрийн системийн шинэчлэл" төслийн талаар Монголбанкны Төлбөр тооцооны газрын Хяналт зохицуулалтын хэлтсийн захирал Ц.Гарьдтай ярилцлаа.

■ Монголбанкны хэрэгжүүлж буй "Төлбөрийн системийн шинэчлэл" төслийн хүрээнд ямар шинэчлэл хийж байгаа тухай юуны өмнө товч мэдээлэл өгнө үү?

Монголбанк нь 2016 оноос эхлэн Азийн хөгжлийн банк (АХБ)-ны дэмжлэгтэйгээр "Төлбөрийн системийн шинэчлэл" төслийг хэрэгжүүлж эхлээд байна. Өнгөрсөн 2 жилийн хугацаанд Монголбанк нь төслийг хэрэгжүүлж, өөрийн Үндэсний цахим гүйлгээний төв (ҮЦГТ)-ийн сүлжээ, техник хангамж болон дата төвүүдийн шинэчлэл, банк хоорондын их дүнтэй гүйлгээний систем (RTGS) болон бага дүнтэй гүйлгээний систем (ACH +)-ийн шинэчлэл, үндэсний ₮ картын шинэчлэл болон цаашид шинэчлэхээр төлөвлөж байгаа бусад төлбөрийн системийн техник болон бизнесийн шаардлагыг олон улсын

зөвлөхүүдээр боловсруулсан зэрэг олон ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Энэ төслийг амжилттай хэрэгжүүлснээр улс үндэстнийг бүхэлд нь хамарсан төлбөрийн цогц үйлчилгээ бүхий найдвартай төлбөрийн системтэй болж төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, ирээдүйд өсөн нэмэгдэх төлбөр тооцооны системийн найдвартай байдлыг хангахад чухал ач холбогдолтой бөгөөд дараах үр дүнгүүд гарна гэж тооцож байна. Үүнд: Төлбөрийн системийн уялдаа холбоог сайжруулж, хяналтыг нэмэгдүүлсэнээр өндөр нууцлалтай, уян хатан цахим төлбөрийн системтэй болох, цахим төлбөрийн үйлчилгээ, бүтээгдэхүүнүүд бий болох хөрс суурийг бий болгож, бэлэн бус төлбөр тооцоог нийтийн хэрэглээ болгох ба ингэснээр далд

эдийн засгийг бууруулах, эдийн засгийн мэдээллүүдийг ил тод болгох, цахим засаглал хөгжихөд дэмжлэг үзүүлэх, үндэсний хэмжээнд төлбөр гүйцэтгэх боломж бүхий, өөрөөр хэлбэл зах зээлийн оролцогч болгонд тохирсон төлбөрийн хэрэгслүүдийг нэвтрүүлэх, банк санхүүгийн үйлчилгээ авахад иргэдийн цаг хугацааг хэмнэх, бүс нутгийн байршлын ялгааг арилгах, Засгийн газрын үнэт цаас, Төв банкны үнэт цаас зэрэг үнэт цаасны нэгдсэн бүртгэлийн системийг сайжруулснаар үнэт цаасны төлбөрийн системийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ гэж үзэж байна.

■ Төслийг хэрэгжүүлснээр төлбөр тооцооны аюулгүй байдлын баталгааг хэр найдвартай төвшинд хүргэхээр зорьж байна вэ?

Төлбөр тооцооны дэд бүтэц,

үндсэн системүүд аль ч улсад Төв банкны хяналтад байдаг, үндэсний аюулгүй байдалд онцгой нөлөөтэй дэд бүтцэд тооцогддо, манай улсын хувьд Монголбанк банк хоорондын төлбөр тооцооны үндсэн сүлжээ, дэд бүтцийг байгуулан хариуцаж ажилладаг. “Төлбөрийн системийн шинэчлэл” төслийг хэрэгжүүлэх үндсэн зорилтуудын нэг нь хэрэглэгчдийн бүх давхаргад тохирсон, харилцан нягт уялдаа холбоотой, өндөр нууцлал бүхий төлбөрийн систем бий болгох явдал юм. Төслийн хүрээнд бид ҮЦГТ-ийн банк дундын үндсэн сүлжээний өргөтгөл, сүлжээний нууцлал, аюулгүй байдлын төхөөрөмжүүдийн бүрэн шинэчлэлийг хийж дуусгаад байна. Өөрөөр хэлбэл, банк дундын төлбөр тооцооны сүлжээний дэд бүтэц, аюулгүй байдалд хөрөнгө оруулалт хийж сайжруулсан гэсэн үг юм. Мөн анх удаа энэ онд банк дундын цахим гарын үсгийн баталгаажуулалтын систем (PKI system), түүний техникийн дэд бүтцийг төслийн хүрээнд ҮЦГТ-д бий болголоо. Банк, санхүүгийн байгууллага дундын мэдээлэл солилцоо, төлбөр тооцоог цахим гарын үсгээр баталгаажуулж, нууцлал аюулгүй байдлыг өндөр төвшинд хангах боломжтой болж байна гэсэн үг. Мөн төслийн явцад үндэсний Ү карт чип технологитой болгож, картын гүйлгээний аюулгүй байдлыг сайжруулах, банк дундын Tokenization систем нэвтрүүлж гүйлгээг нууцлалтайгаар дамжуулж эхлэх зэрэг бусад дэд бүтцийн шинэчлэлийн ажлууд хийгдэнэ.

■ Төслийн үр дүнд манай төлбөрийн системийн хөгжил олон улсын жишигт хүрэх үү? Эдгээр шинэчлэлтийн үр дүнд харилцагчдад ямар давуу боломжууд бий болох вэ?

Мэдээж “Төлбөрийн системийн шинэчлэл” төслийг хэрэгжүүлснээр Монгол Улсын төлбөр тооцоог олон улсын хөгжлийн хамгийн сүүлийн үеийн жишигт хүргэсэн, түүнд суурилсан үр дүнтэй, аюулгүй байдал нь хангагдсан, харилцан уялдаа холбоо бүхий төлбөрийн системтэй болгохоор зорьж байна. Үүний тулд Монголбанкны болон ҮЦГТ-ийн суурь сүлжээ, төлбөр тооцооны системүүдийг шинэчилж байна, олон шинэ дэвшилтэт төлбөрийн хэрэгсэл, сувгийг нээх боломжийг бий болгож байна. Суурь дэд бүтцийн шинэчлэлийн ажил тэр даруй үр дүнгээ өгч, иргэдийн хэрэглээнд тэр бүр анзаарагдахгүй ч, банк болон бусад финтек компаниудын бүтээгдэхүүн үйлчилгээгээр дамжин ойрын ирээдүйд тун удахгүй үр дүнгээ өгч эхлэх болно.

■ Манай улсын онцлог гэж байх уу?

Улс орнуудын болон дэлхийн нийтийн төлбөр тооцооны системүүд нь харилцан уялдаа бүхий нэг цогц гэж болно. Технологийн дэвшил, түүнд суурилсан төлбөр тооцооны бүтээгдэхүүн, хөгжил нь тухайн улсын онцлог гэхээсээ илүүтэйгээр харилцан уялдаатай байдлыг чухалчилж, нэг стандарттай байх гэдэг ойлголт нь илүү байж, улс орнуудын төв банкууд, төлбөр тооцооны глобал компаниуд

(VISA, MasterCard, UPI г.м) энэ чиглэлд илүүтэй ажилладаг. Манай төслийн хувьд ч ялгаагүй олон улсын жишигт нийцсэн бусад улс орон, бүс нутаг, глобал төлбөр тооцооны компаниудтай харилцан уялдаа холбоо бүхий, нэгдсэн интеграцид орох боломжтой, олон улсын жишиг стандартад суурилсан шинэчлэлийг хийхээр зорьж байна. Нэгдсэн стандарт, олон улсын түгээмэл жишигт суурилах хэдий ч, мэдээж хэрэг, төлбөр тооцооны бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгохдоо улсынхаа онцлогт тохируулна. Жишээ нь манай улс өргөн уудам нутаг дэвсгэртэй, цөөн хүн амтай, байгалийн эрс тэс уур амьсгалтай улс. Мөн хоёр том улстай хиллэдэг гэх мэт манай улсын өвөрмөц онцлог бий. Энэ онцлогийг харгалзан гар утсанд илүү суурилсан, газар нутгийн хол ойроос үл шалтгаалсан бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргахаар банкууд, компаниуд ч хичээж байна. Төв банкны төлбөр тооцооны системийн бодлого, банкуудын шинэ дэвшилтэт цахим төлбөр тооцооны бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд эдгээр онцлогийг тусгах ёстой.

■ Дэлхийн улс орнуудад одоогийн байдлаар шинэ дэвшилтэт цахим төлбөрийн үйлчилгээний хөгжлийн хандлага ямархуу байна вэ. Хамгийн өргөн хэрэглэгдэж буй, жишиг болон яригдаж буйгаас нь сонирхуулаач?

Технологийн дэвшлийн хурдтай хөгжилд суурилан төлбөр тооцоо, цахим төлбөрийн хэрэгслүүд, шинэ үйлчилгээ, боломжууд маш



хурдтайгаар шинэчлэгдсээр байна. Карт болон гар утсанд суурилсан төлбөрийн хэрэгслүүд дэлхийн хамгийн түгээмэл цахим төлбөр тооцооны хэрэгслүүд байсаар байгаа боловч гар утсанд суурилсан уламжлалт төлбөр тооцооны үйлчилгээг бүр илүү хялбарчлан, хэрэглэгчдэд энгийн болгосон, худалдаа эрхлэгчдийн хөрөнгө оруулалтын зардлыг бууруулсан үр ашигтай төлбөрийн хэрэгслүүд сүүлийн жилүүдэд бусад улс оронд хөгжиж, үр дүнгээ өгч байна. Үүний хамгийн сайн жишээ нь QR кодоод суурилсан болон гар утасны зайнаас унших технологи буюу NFC технологийг ашигласан төлбөрийн хэрэгслүүд юм. Жишээ нь манай урд хөршид QR кодоод суурилан гар утсаар үзүүлдэг WePay болон AliPay зэрэг төлбөрийн хэрэгслүүд нийт бэлэн бус төлбөр тооцооны дийлэнх хувийг гүйцэтгэдэг болж байна. Мөн АНУ, Европын орнуудад NFC технологид суурилсан Apple Pay болон Samsung Pay үйлчилгээнүүд улам бүр боловсронгуй болж,

хүртээмж нь нэмэгдсээр байна.

■ Төлбөрийн картууд зайнаас хүртэл уншигддаг болж, гар утаснаасаа төлбөр тооцоо хийдэг боллоо. Манай улсад ч нэвтэрч эхэлсэн. Энэ бүхнийг бүх нийтийн хэрэглээ болгох, бүр илүү төвшинд хүргэх, олон шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгоход хэр их цаг хугацааны бэлтгэл орох бол?

Төлбөрийн картууд манай улсын иргэдийн төлбөр тооцооны үндсэн хэрэгслүүдийн нэг болоод байна. 2012 онд Монголбанкнаас санаачилж, арилжааны банкуудтайгаа хамтран үндэсний ₮ картыг зах зээлд гаргасан бөгөөд өнөөдрийн байдлаар Монгол Улсад гаргасан нийт картын 70 гаруй хувь буюу 2,9 сая ширхэгт хүрсэн. Мөн банкууд гар утас болон интернетэд суурилсан төлбөр тооцооны шинэ боломж, хэрэгслүүдийг аль хэдийн хэрэглэгчиддээ хүргэж, хүртээмжийг нь нэмэгдүүлсээр байна.

Технологийн хөгжлийн боломж ч хэрэглээг нэмэхэд түлхэц үзүүлж байна. Мөн Үндэсний төлбөрийн системийн тухай хуультай болсноор сүүлийн жилүүдэд банк бус төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэгч компаниуд, банк бус санхүүгийн байгууллагууд төлбөр тооцооны оролцогч болох боломжтой болж төрөл бүрийн гар утас, QR код, интернет болон бусад төрөл бүрийн технологийн боломжид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд гаргасаар байгааг иргэд анзаарч байгаа байх.

Төслийн хүрээнд Монголбанк нь эдгээр шинэ дэвшилтэт технологид суурилсан үйлчилгээг дэмжих олон ажил төлөвлөж байна. Таны асуусанчлан, Монголбанк үндэсний ₮ картаа шинэчлэх, ₮ картаа нууцлалын чиптэй болгох, зайнаас унших боломжтой болгон хөгжүүлэхээр олон улсын зөвлөхүүдтэй ажиллаж байна. 2019 оны дунд гэхэд үндэсний ₮ карт олон улсын нууцлал аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан чип, зайнаас унших технологитай гарч эхэлнэ. Мөн гар утаснаас төлбөр тооцоо хийх технологийг дэмжихийн тулд Монголбанк нь төслийн хүрээнд гүйлгээний нууцлал аюулгүй байдлыг баталгаажуулах банкны гүйлгээ баталгаажуулах төв буюу үндэсний Токен баталгаажуулагч системийг ҮЦГТ-д бий болохоор ажиллаж байна. Ойрын жилд эдгээр систем нэвтэрч, түүнд суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээнүүд нь бодит хэрэглээ болно.

■ **Дээр үндэсний төлбөрийн хэрэглээний онцлогийг ярьсан. Энэ чиглэлийн мэргэжилтнүүд хэр бэлтгэгдсэн бэ, үндэсний мэргэжилтнүүд өөрийн онцлогтой шинэ төлбөр тооцооны үйлчилгээг бий болгох талаар? Хүний нөөцийн чадамжийг сайжруулах талаар ажил хийгдэх үү?**

Мэдээллийн технологийн мэргэжилтнүүд, төлбөр тооцооны мэргэжилтнүүд, үндэсний банкууд, компаниуд дэлхийн жишигт хүрсэн, өөрсдийн онцлогт тохирсон бүтээгдэхүүн үйлчилгээ гаргаж байгааг бид харж байгаа шүү дээ. Төлбөр тооцоо, цахим бүтээгдэхүүн бий болгох, хөгжүүлэх ажилд олон жил манай банкууд түүчээлэн ажиллаж, үндэсний мэргэжилтнүүдийг бий болгох, туршлагажуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн гэж боддог. Энэ суурин дээр үндэслээд одоо зөвхөн банк гэхгүй, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч хувийн компаниуд буюу финтек компаниуд сүүлийн үед олноор бий болж энэ салбарт өрсөлдөж байна. Монголбанкны санаачилж бий болгосон Үндэсний төлбөрийн системийн тухай хууль банк бус компаниуд энэ салбарт оролцогч байх, санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгогч байх боломжийг олгосон нь эдгээр компаний хөгжил, хүний нөөцийн чадавхын хөгжилд эергээр нөлөөлж, дэмжлэг болно.

Таны асууснаар төслийн хүрээнд хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэх дэд төслийн хэсгүүд бий.

Монголбанкны болон арилжааны банкуудын мэдээллийн технологи, төлбөр тооцооны холбогдох мэргэжилтнүүдийн чадавхыг сайжруулах, сургалтад хамруулах ажил үе шаттайгаар хийгдэнэ.

■ **Блокчейн технологи нь төлбөрийн системд хүлээн зөвшөөрөгдөх технологи мөн эсэхэд ярилцлагын төгсгөлд мэдээлэл авахыг хүсч байна.**

Хүлээн зөвшөөрөгдөх гэснээс ер нь анх блокчейн технологи төлбөр тооцоотой холбоотойгоор үүссэн шүү дээ. Биткойны анхны зорилго нь бусдаас үл хамаарсан, төвлөрөөгүй, ил тод, баталгаатай, хүн бүхэнд хүртээмжтэй төлбөр тооцоог бий болгох зорилготой байсан гэж үздэг. Энэ чиглэлээр төдийгүй бусад чиглэлээр блокчейн технологи маш хурдтай хөгжиж, ямар төвшинд хүрч байгаа, ямар сорилтуудтай тулгарч явааг бид бүхэн харж байна. Зөвхөн төлбөр тооцоо төдийгүй банк, санхүүгийн бүх үйлчилгээнд блокчейн технологийг ашиглах, үр ашигтай болгох, ил тод болгох, баталгаатай болгох төрөл бүрийн санаачилга, төслүүд дэлхий даяар өрнөж байна. Блокчейн технологид суурилсан биржийн арилжааг хийх талаарх санаачилга манай компаниудаас гарсан, хэд хоногийн өмнө бүтээгдэхүүн нь танилцуулагдсаныг мэдэх байх. Тэгэхээр блокчейн технологи төлбөр тооцооны системд зөвшөөрөгдөх бүрэн боломжтой төдийгүй, техник технологийн хөгжил энэ боломжийг ойрын хугацаанд авч ирэх болов уу гэж бодож байна.

Харин биткойн зэрэг криптовалютууд нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулиар тодорхойлсон цахим мөнгөний шинжүүдийг хангадаггүй, мөн Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэрт бараа, ажил, үйлчилгээний төлбөрийг зөвхөн төгрөгөөр хийх тул криптовалютыг Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглах албан ёсны төлбөрийн хэрэгсэл биш болохыг Монголбанкнаас урьд өмнө нь хэд хэдэн удаа мэдэгдэж байсан. Нэг ёсондоо, дэлгүүрээс бараа худалдаж аваад түүний төлбөрт нь биткойн өгч болохгүй, хуулиар хориотой гэсэн үг.

■ **Сонирхолтой ярилцлага өгсөнд баярлалаа.**



МОНГОЛБАНКНЫ ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРЛААС (2018.11.27)

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 11 дүгээр сарын 27-нд ээлжит бусаар хуралдаж, бодлогын хүүг 1 нэгж хувиар нэмэгдүүлж, 11 хувьд хүргэх шийдвэр гаргалаа. Мөнгөний бодлогын хорооны шийдвэртэй холбоотойгоор сэтгүүлчдийн асуултад Монголбанкны удирдлагууд дараах байдлаар хариулав.

Мөнгөний бодлогын газрын захирал

Б.БАЯРДАВАА:

Монголбанкны мөнгөний бодлогын хорооны ээлжит бус хурлаар бодлогын хүүг 1 нэгж хувиар өсгөж, 11 хувьд хүргэх шийдвэр гаргалаа. Энэхүү шийдвэрийг гаргахад хэд хэдэн хүчин зүйл нөлөөлсөн. Сүүлийн үед эдийн засгийн идэвхжил харьцангуй өндөр төвшинд гүйцэтгэлтэй байна. Үүнд нэгдүгээрт, гадаад зах зээл дээр харьцангуй өндөр төвшинд тогтож байгаа экспортын бүтээгдэхүүний үнэ нөлөөлж байна. Нөгөө талаас хөрөнгө оруулагчдын итгэл сайн байгаа. Энэ нь зээлжих зэрэглэлийн агентлагууд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулж буйгаар харагдаж байна. Түүнчлэн төсөв болон мөнгөний бодлогын оновчтой арга хэмжээнүүд макро эдийн засгийг богино хугацаанд тогтворжуулж, дунд, урт хугацаанд тогтвортой өсөлтийн замд нь гаргаж ирэх бодлогууд үр дүнтэй хэрэгжиж байна. Энэ нөхцөл байдлын тод илрэл нь хөдөлмөрийн зах зээл дээр ажилгүйдлийн төвшин 6.9 хувь болж, буурснаар харагдлаа. Мөн ажил эрхлэлтийн төвшин жилийн өмнөхөөс 4.4 хувиар өссөн бөгөөд сүүлийн 1-2 жилийн хугацаанд тасралтгүй нэмэгдэж байгаа нь хөдөлмөрийн зах зээл дээр гарч

ирж байгаа сайн үзүүлэлт болж байна. Нөгөө талаас Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтууд эдийн засагт тасралтгүй орж ирж байна. Энэ бүх зүйлүүд эдийн засагт таатай нөлөөллийг үзүүлж байна. Үүнтэй зэрэгцээд 2016 оны 12 дугаар сараас хойш Монголбанкнаас бодлогын хүүг шат дараатайгаар бууруулсан нь эдийн засагт гарч байгаа зээлийн нөхцөлийг сайжрууллаа. Энэ нь юуны өмнө зээлийн хүү тогтвортой буурч байгаагаар, зээлийн нийлүүлэлт нэмэгдсэнээр харагдаж байгаа. Инфляцийн төвшин Монголбанкны зорилтот төвшинд байна. Монголбанкны зорилтот төвшин ирэх 2020 он хүртэл инфляцийг 8 хувьд тогтворжуулах, 2021 оноос эхлэн 6 хувь руу бууруулах Үндсэн чиглэлийг батлуулсан. Хэдийгээр дотоод эдийн засгийн идэвхжил сэргэж, инфляци зорилтот төвшинд байгаа хэдий ч үүний нөгөө талд харгалзан үзэх зайлшгүй хүчин зүйлүүд байна гэж үзсэн.

Тухайлбал, гадаад хүчин зүйл дотоод эдийн засагт хүчтэй нөлөөлж байна. Монгол Улсын эдийн засаг гадаад орчноос хамаарал ихтэй, экспортын бараа, бүтээгдэхүүний 70 орчим хувь нь зөвхөн гурван бүтээгдэхүүний экспорт, түүний орлогоос хамаардаг.

Энэ нөхцөл байдал нь эдийн засагт гадаад орчны хүчин зүйлийг зайлшгүй харгалзан үзэх нөхцөл байдлыг үүсгэж байна. Энэхүү нөхцөл байдлыг Монголбанкны мөнгөний бодлогын хорооны есдүгээр сарын хуралдааны тэмдэглэлээс та бүхэн харж болно. Хурлын тэмдэглэлд эдийн засгийн нөхцөл байдал, гадаад орчны тодорхой бус байдал үргэлжилж, төлбөрийн тэнцэл дээр дарамттай нөхцөл байдал үүсвэл мөнгөний бодлогын хүүг өсгөх асуудлыг хэлэлцэнэ гэж дурдсан. Үүний дагуу мөнгөний бодлогын хороо хуралдаж, бодлогын хүүг өсгөх шийдвэр гаргалаа.

Дотоод талаасаа харгалзан үзэх хүчин зүйлийн тухайд ирэх жил эдийн засагт нэлээд том дэмжлэг орж ирнэ. Нэгэнт төсвийн бодлого талаасаа тэлэлт явагдаж байгаа нөхцөлд нийт макро эдийн засгийнхаа тэнцвэрийг хадгалахын тулд мөнгөний бодлого дээр зайлшгүй арга хэмжээ авах шаардлагатай болсон. Ингэснээр макро эдийн засгийн дунд, урт хугацааны тогтвортой байдлыг хадгална гэж мөнгөний бодлогын хороо үзсэн.

Блүүмбэрг ТВ: 12 дугаар сараас эхлэн 28 долоо хоногтой ТБҮЦ гаргахаар болсон байна. Энэ шийдвэрийг гаргах цаад үндэслэл, шалтгаан нь юу байна вэ?

НУСЗЗГ-ын захирал **А.ЭНХЖИН:**

Төв банкнаас өнөөдрийн байдлаар 28 хоногтой буюу 4 долоо хоногийн хугацаатай үнэт цаасыг долоо хоног бүрийн даваа гарагт арилжаалж байгаа. Одоогийн байдлаар ТБҮЦ-ны үлдэгдэл 4.7 их наяд төгрөгт хүрсэн. ТБҮЦ-ны үлдэгдэл сүүлийн жилүүдэд эрс өсч байна гэх шүүмжлэл бий. Тэгэхээр Төв банкны хувьд банк хоорондын зах дээр байгаа илүүдэл нөөцийг үнэт цаас гаргаж, өөр дээрээ татах замаар ханш, инфляцид ирэх дарамтыг удирддаг. Тэгэхээр төв банк үнэт цаас гаргаж, банк хоорондын зах дээр байгаа илүүдэл нөөцийг татаж авахгүй бол банкууд энэ нөөцөө валют руу оруулах, эсвэл эрсдэл өндөртэй зээл гаргах замаар эдийн засгийн тэнцвэргүй байдлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй. Үүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор төв банк үнэт цаас гаргаж, илүүдэл нөөцийг татаж авдаг. Тэгэхээр бид 4 долоо хоногтой үнэт цаасныхаа хугацааг сунгаад, 28 долоо хоногтой үнэт цаасыг маргаашаас эхлэн банкуудад арилжаалж эхлэхээр боллоо. Энэхүү

шийдвэрийг гаргаснаар банкуудын илүүдэл нөөцийг удирдахад үр өгөөжтэй алхам болно. Банкуудын хувьд үүсээд байгаа нэг хүндрэл нь юу гэхээр 2017 оны намраас хойш ЗГҮЦ-ны арилжааг зогсоосон. Тэгэхээр банкуудын хувьд дотоодын зах зээл дээр хөрөнгө оруулж болох хамгийн урт хугацаатай хэрэгсэл нь өнөөдрийн байдлаар 4 долоо хоногтой ТБҮЦ байгаа. Тэгэхээр Төв банкнаас 6 сарын хугацаатай үнэт цаасыг гаргаснаар банкууд нөөцөө урт хугацаатай хөрөнгө оруулалтад байршуулах боломжтой болно. Одоо мөрдөж байгаа журмын дагуу банкууд нийт активынхаа 25 хувийг түргэн хөрвөх чадвартай хөрөнгөд байршуулах шаардлагатай. Тэгэхээр Засгийн газар үнэт цаас гаргахаа зогсоосон. Төв банкны үнэт цаасны үлдэгдэл 4.7 их наяд төгрөг байна гэхээр нийт 30 их наяд төгрөгийн активтай банкны салбарын хувьд 15-16 хувьтай л тэнцэж байна. Ерөнхийдөө банкуудад түргэн хүрэх чадвартай активт хөрөнгө оруулах шаардлага бий. Төв банкнаас 6 хүртэлх сарын хугацаатай үнэт цаас гаргаснаар нэгдүгээрт, нөөцийг удирдах замаар мөнгөний бодлогоо хэрэгжүүлэх боломж, бололцоо сайжирна. Хоёрдугаарт, банкууд урт хугацаатай активт хөрөнгө оруулах боломж нээгдэнэ. Үүнээс гадна Төв банкнаас банкуудад 90 хүртэлх хоногийн хугацаатай репо санхүүжилтийг олгож эхэлсэн. Банкууд 6 сарын хугацаатай ТБҮЦ-ны арилжаанд оролцсоноор энэхүү үнэт цаасаа барьцаалаад Төв банкнаас 90 хүртэлх хоногийн хугацаатай репо санхүүжилтийг авах боломжтой. Ингэснээр зээлийн хүү, хадгаламжийн хүү буурах эерэг нөлөө авчирна.

Өнөөдөр сонин: Мөнгөний бодлогын хүүг өсгөж байгаа нь зээлийн хүүд хэрхэн нөлөөлөх вэ?

Монголбанкны Ерөнхийлөгч **Н.БАЯРТСАЙХАН:**

Бодлогын хүүг нэмэгдүүлж байгаа нь зээлийн хүүнд тодорхой хэмжээгээр нөлөөлнө. Үүнийг бид тооцож тооцож үзсэн. Бодлогын хүү 1 хувиар өсөхөд аж ахуйн нэгж, байгууллагуудад очих зээлийн хүү 0.3 хувиар өсдөг гэсэн тооцоо бий. Тэгэхээр бодлогын хүүг дагаж зээлийн хүү өсөх нөхцөл байдлыг бид үгүйсгэхгүй байгаа. Гэхдээ эдийн засгийн одоогийн нөхцөл байдал бодлогын хүүг нэмэгдүүлэх арга хэмжээ авахаас өөр аргагүй боллоо. Тийм ч учраас бид 12 дугаар сард хуралдах байсан Мөнгөний бодлогын хорооны хурлаа

наашлуулж, 11 дүгээр сард яаралтай хуралдаж, шийдвэр гаргаж байгаа юм.

Монгол ТВ: ОУВС-ийн зүгээс активын чанарын үнэлгээг дахин хийсэн. Үүгээр банкууд өмнөхөөсөө ч муу дүн авсан гэх мэдээлэл байна. Энэ бодитой мэдээлэл үү?

Монголбанкны Дэд Ерөнхийлөгч **Б.ЛХАГВАСҮРЭН:**

Активын чанарын үнэлгээ хийгдээд дууссан. Дахиж, хоёр дахь удаагаа хийсэн зүйл байхгүй. Гэхдээ активын чанарын үнэлгээний дүн тавдугаар сард гарсан. Дүнд үндэслээд, энэ 12 дугаар сарыг дуустал арилжааны банкууд өөрийн хөрөнгөө өсгөх бизнес төлөвлөгөө гаргаад ажиллаж байгаа. Төлөвлөгөөний хэрэгжилт дээр Монголбанк хяналт тавьж байгаа.

Өдрийн сонин: 28 долоо хоногийн хугацаатай үнэт цаас ямар хэмжээтэй, ямар хүүтэйгээр гаргах вэ?

НУСЗЗГ-ын захирал **А.ЭНХЖИН:**

Хүүгийн хувьд бид бодлогын хүү дээр нэмэх нь нэг хувь гэж тогтоож байгаа. Монголбанк бодлогын хүүгээ өсгөж, 11 хувь болгосон. Тэгэхээр 28 долоо хоногтой үнэт цаасны хүү 12 хувь байх юм. Хэмжээний хувьд бид нөөцийнхөө таамаглал дээр үндэслээд, ямар хэмжээгээр арилжаалахаа тухай бүр шийдээд явна. Арилжааны давтамжийн хувьд хоёр долоо хоногт нэг удаа, лхагва гараг бүр зохион байгуулна.

Өдрийн сонин: Төсөв өндөр хэмжээний алдагдалтай батлагдсан гэж та бүхэн хэлж байна. Гэтэл урд хөрш нүүрс авахаа багасгачихлаа. Энэ тохиолдолд төсвийн алдагдал дахиад ч нэмэгдэхээр байна. Энэ алдагдлын нөлөөллийг хэрхэн тооцоолж байгаа вэ?

МБХ-ны гишүүн **Ц.БАТСҮХ:**

Ирэх оны төсөвт 42 сая тонн нүүрс экспортолно гэж тооцоолсон. Түүнийхээ дагуу төсвийн орлогоо нэмэгдүүлж тооцсон. Энэ маягаар явбал, мэдээж төсвийн орлого дутна. Дутагдсан орлогоо яаж нөхөх нь Сангийн яамны асуудал байх.

Блүүмбэрг ТВ: Эдийн засгийн өсөлт тогтвортой байна гэж Төв банкнаас мэдэгдэж байгаа. Ирэх оны тухайд энэ тогтвортой байдлыг алдагдуулах хамгийн гол эрсдэлүүдийг Төв банк хэрхэн харж, тооцоолж

байгаа вэ? Мөн Мөнгөний бодлогын хорооны өмнөх хурлаар Төв банкны зүгээс ханш тогтвортой байна гэж мэдээлж байсан. Гэтэл өнөөдөр 2600 төгрөгийг давчихлаа. Үүний шалтгаан юу байв?

Монголбанкны Ерөнхийлөгч **Н.БАЯРТСАЙХАН:**

Бид 2016 онд ихээхэн төвөгтэй, эдийн засгийн өсөлт саарсан, инфляци бус дефляци болсон, хүндрэлтэй нөхцөл байдалд Монголбанкны удирдлагад ирсэн. Сүүлийн хоёр жилийн хугацаанд авч хэрэгжүүлсэн эдийн засгийн шинэчлэл, өөрчлөлтийн арга хэмжээний үр дүнд нөхцөл байдал нэлээд наашилсан. Эдийн засгийн өсөлт сайжирсан. Гуравдугаар улирлын эдийн засгийн өсөлт 6.7 хувьтай гарлаа. Зээлийн хүү ч бас дунджаар жилийн 21-22 хувь байсан нь одоо буурч, 17-18 хувь болсон байна. Ажилгүйдэл буурч байна. Ажлын байрны тоо өслөө гэх зэргээр эдийн засагт нааштай, гэрэл гэгээтэй үзүүлэлтүүд гарч байгаа. Гэхдээ манай эдийн засагт эрсдэл нэлээд үүсч эхэллээ. Тийм учраас Монголбанк холбогдох шийдвэрийг гаргах шаардлагатай гэж үзсэн. Юуны өмнө энэ бол манай гадаад зах зээлтэй холбоотой байна. Та бүхний мэдэж байгаа арилжааны экспортын хэмжээнд нэлээд хязгаарлалт хийх нөхцөл байдал үүслээ. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд Засгийн газар хурдан шуурхай арга хэмжээ авч, нөхцөл байдлыг сайжруулах байх гэж Монголбанк харж байгаа. Түүнээс гадна АНУ-ын Төв банк бодлогын хүүгээ нэмэгдүүлсэн. Цаашид ч нэмэгдүүлэх магадлалтай байна. Үүнтэй холбоотойгоор ганц Монголд бус хөгжиж байгаа бүх улс орны зах зээлээс хөрөнгө гадагшлах процесс дэлхий даяар явагдаж байгаа. Ийм нөхцөл байдалд хөгжиж байгаа орнууд өөрсдийн үндэсний мөнгөн тэмдэгийн өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч байна. Тэгэхээр өнөөдөр Монголбанк бодлогын хүүгээ нэмэгдүүлж байгаа нь үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөө хадгалах, үнэ цэнийг нь нэмэгдүүлэх чиглэлээр авч байгаа арга хэмжээ юм. Нөгөө талаар гадагшаа урсаж байгаа хөрөнгийн хэмжээг бага ч болов татах зорилготой арга хэмжээ. Мөн чадвал гаднаас орж ирэх хөрөнгийн урсгалыг Монгол руу чиглүүлэх зорилгоор авч хэрэгжүүлсэн бодлогын томоохон арга хэмжээ юм.

Ханшийг тогтворжуулахад аль ч орны төв банкинд байдаг үндсэн хэдхэн л арга хэмжээ бий. Бид бүгдийг нь хэрэглэж байгаа. Нэгдүгээрт, бид ханшийг

тогтворжуулахын тулд зах зээл дээр валютын интервенц хийдэг. Оны эхнээс хойш Монголбанк нийт 979 сая ам.долларын интервенцийг хийсэн байна. Тэгэхээр бид төгрөгийн ханшийг тогтворжуулах, аж ахуйн нэгж, иргэдийн валютын хэрэгцээг хангах чиглэлээр ажиллаж байна. Өөр нэг арга нь бодлогын хүүг нэмэгдүүлэх. Бодлогын хүүг нэмэгдүүлэхийн цаад учир шалтгааныг та бүхэн мэдэж байгаа. Энэ бол аж ахуйн нэгж, иргэдийн гар дээр байгаа хөрөнгийн чөлөөт эх үүсвэрийг Төв банк өндөр бодлогын хүү зарлах замаар өөр дээрээ үнэт цаас гаргаж, төвлөрүүлж авдаг арга хэрэгсэл. Энэ аргыг өнөөдөр маш олон оронд хэрэглэж байна. ОХУ-ын төв банк сая шийдвэрээ гаргасан. Өмнө нь Турк, Аргентин зэрэг улс орны төв банкууд бодлогын хүүгээ нэмэгдүүлсэн. Бид ч бас цаашид ийм аргыг хэрэглэж байгаа нь ханшийг тогтворжуулах нэг арга гэж ойлгох хэрэгтэй.

ТВ9: УИХ-ын гишүүн О.Баасанхүү ипотекийн зээлийн хүүг 3 хувь болгож бууруулах боломжтой гэж мэдэгдээд байгаа. Тэгэхээр ингэж бууруулах боломжтой юу, УИХ-ын гишүүн О.Баасанхүүгийн зүгээс та бүхэнд энэ талаар албан ёсоор хандсан зүйл байгаа юу?

Монголбанкны Ерөнхийлөгч **Н.БАЯРТСАЙХАН:**


Бидэнд одоогоор албан ёсны санал УИХ-ын гишүүнээс ирээгүй байна. Одоогоор ипотекийн хөтөлбөрийн санхүүжилт яаж явагдаж байгаа вэ гэхээр Монголбанкнаас 4 хувийн хүүтэй эх үүсвэрийг арилжааны банкуудад олгож байгаа. Арилжааны банкууд түүнийг 8 хувь болгоод, орон сууц авна гэсэн иргэдэд олгож байгаа. Бид өнөөдөр мөнгөний бодлогын хүүг 11 хувьд хүргэх шийдвэр гаргаж байна. Тэгэхээр Монголбанкны мөнгөний бодлогын хүүнээс хэд дахин бага хүүгээр бид арилжааны банкуудад зээл олгож байгаа. Энэ хоорондын зөрүү Монголбанкны алдагдал болж байгаа. Тийм ч учраас ОУВС-ийн зүгээс тавьж байгаа нэг шаардлага нь аливаа улс оронд ипотекийн хөтөлбөрийг Засгийн газар, Сангийн яам нь хэрэгжүүлдэг. Төв банк хэрэгжүүлдэггүй. Тийм учраас

үүнийг Засгийн газарт шилжүүлэх ёстой гэж үзэж байгаа. Уг нь 2019 оны нэгдүгээр сарын 1-нээс бид Засгийн газарт шилжүүлэх ёстой байсан. Гэвч Засгийн газрын нөхцөл байдлыг та бүхэн мэдэж байгаа. Асар их хэмжээний буюу 1.9 их наяд төгрөгийн алдагдалтай төсөв батлагдсан. Үүн дээр нэмээд ипотекийн хөтөлбөрийг шилжүүлбэл төсвийн алдагдал их хэмжээгээр нэмэгдэнэ. Тийм учраас Монголбанк Засгийн газартайгаа хамтраад хөтөлбөрөө 2019 онд үргэлжлүүлнэ. Энэ асуудлыг яаж шийдвэрлэх вэ гэдэг гарц, шийдлийг бид бүхэн хайж байгаа. Дэлхийн банкнаас техникийн туслалцаа үзүүлж байгаа. Энэ туслалцааны үр дүн хараахан гараагүй байна. Тэгэхээр 2019 ондоо бид дахин үргэлжлүүлье гэдэг зарчим дээр Засгийн газартай тохирсон.


Өдрийн сонин: Төсөв баталж байх үед та бүхэн ийм өндөр алдагдалтай баталж болохгүй гэж Засгийн газарт хэлсэн үү? Одоо тэгээд төсвийн алдагдал бүр өндөр болох асуудал гарч ирэхээр Монголбанк энэ Засгийн газрын асуудал гэдэг байдлаар хандаж болох уу?

Монголбанкны Ерөнхийлөгч **Н.БАЯРТСАЙХАН:**

Маш олон нөхцөл байдал үүсээнийг та харж байгаа. Нэгдүгээрт, нүүрсний тээвэрлэлт дээр ямар нөхцөл байдал үүсээд, хэчнээн километр машины цуваа үүссэн нь ойлгомжтой байгаа. Хоёрдугаарт, улс төрийн нөхцөл байдал шууд нөлөөлж байна. Монгол хүн гэдэг чинь бүх юмыг анхааралтай хараад сууж байдаг. Улс төрийн нөхцөл байдал үүсээд, жаахан бужигнаан гараад эхлэхээр маш болгоомжлох, хамгаалах нөхцөл байдал руу шилжиж байна. Энэ бүх нөхцөл байдлыг харгалзаж үзээд, миний гаргасан шийдвэр дээр УИХ-аас томилсон Мөнгөний бодлогын хорооны гишүүд ярилцаад, мөнгөний бодлогын төлөвийг чангаруулах зайлшгүй нөхцөл байдал үүслээ гэж үзсэн. Энэ бол Монгол Улсын эдийн засгийн тогтвортой байдал, санхүүгийн тогтвортой байдлыг хамгаалахад чиглэсэн бодлогын шийдвэр юм.





Зураг 1.1. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц



- М2 мөнгөний жилийн өсөлт 26.3%-д хүрч 18.3 их наяд ₮-т хүрэв.
- Өмнөх сараас 2.3%-иар буюу 412.3 тэрбум ₮-өөр өсөв.
- Үүнээс, М1 мөнгө 0.6% (21.1 тэрбум ₮), бусад хадгаламж 2.7% (391.2 тэрбум ₮) –иар өссөн байна.
 - М1 → ₮-ийн харилцах 63.7 тэрбум ₮-өөр, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 42.6 тэрбум ₮-өөр буурав.
 - Бусад хадгаламж → \$-ийн харилцах 439.0 тэрбум ₮-өөр, \$-ийн хадгаламж 22.1 тэрбум ₮-өөр, ₮-ийн хадгаламж 69.8 тэрбум ₮-өөр буурав.

Зураг 1.2. Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өөрчлөлт, тэрбум ₮




Зураг 1.3. Мөнгөний нийлүүлэлтийн бүтэц




- Нийт М2 мөнгөний нийлүүлэлтийн 51.5%-ийг ₮-ийн хадгаламж бүрдүүлж байгаа бол 14.9%-ийг валютын хадгаламж, 15.5%-ийг ₮-ийн харилцах, 14.8%-ийг валютын харилцах, үлдсэн 3.3%-ийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө бүрдүүлж байна.
- Нийт хадгаламжийн хэмжээ 12.2 их наяд ₮-т хүрснээс 83.2%-ийг иргэдийн хадгаламж, 16.2%-ийг байгууллагын хадгаламж бүрдүүлж байна.
- Иргэдийн хадгаламжийн 19.1%-ийг, байгууллагын хадгаламжийн 41.3%-ийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байна.

Зураг 1.4. Нийт хадгаламж




Зураг 1.1. Нийт шинээр татсан хадгаламж, хүү




Тайлант сард:

- Иргэдээс татсан ₮-ийн хадгаламжийн ЖДХ 11.7 хувь, хувийн байгууллагаас татсан ₮-ийн хадгаламжийн ЖДХ 11.2 хувь байна.
- Иргэдэд шинээр олгосон ₮-ийн зээлийн ЖДХ 18.5 хувь, хувийн байгууллагад олгосон ₮-ийн зээлийн ЖДХ 16.2 хувь байна.


Зураг 1.2. Нийт шинээр олгосон зээл, хүү



Зураг 1.3. Нийт хадгаламжийн үлдэгдэл, хүү



Зураг 1.4. Нийт зээлийн үлдэгдэл, хүү



Тайлант сард:

- Иргэдийн Т-ийн хадгаламжийн ЖДХ 12.3 хувь, хувийн байгууллагын Т-ийн хадгаламжийн ЖДХ 11.7 хувьтай байна.
- Иргэдийн Т-ийн зээлийн ЖДХ 18.6 хувь, хувийн байгууллагын Т-ийн зээлийн ЖДХ 15.5 хувьтай байна.

Тайлант сард олгосон зээл

Зураг 3.1. Тайлант сард олгосон ипотекийн зээл



Тайлант сард банкууд 726 зээлдэгчид 57.1 тэрбум Т-ийн ипотекийн зээл шинээр олгосноос 22.8% нь хөтөлбөрийн, 77.2% нь банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл байв.

Зээлийн үлдэгдэл

Зураг 3.2. Тухайн сард олгосон ипотекийн зээлийн хүү




Тухайн сард олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 13.1%-тай байна.

Төлбөрийн тэнцэл

Гадаад сектор

4.1. Төлбөрийн тэнцлийн статистик, 2018 оны эхний 10 сар



МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

ӨВГӨНТ УУЛЫН ОЛДВОРУУД: РУНИ БИЧЭЭС

БҮХИЙ ХӨӨМӨЛ АЛТАН ЧИМЭГ

Нийтийн тооллын VII-IX зуун

Хосгүй үнэт

Голч: 2.78 см

Жин: 2.1 гр



1983 онд Булган аймгийн Бүрэгхангай сумын Өвгөнт ууланд археологич Д.Наваан, Х.Лхагвасүрэн нарын малтсан хос морь дагалдуулсан нэгэн булшнаас руни бичигтэй, хүний хөрөг бүхий хөөмөл дугуй чимэглэл, морины хударга, хөмөлдрөгний алтан товруу, хүрэл зүрхэвч зэрэг олдворууд илэрчээ. Хөөмөл аргаар хийсэн хагас товгор, нимгэн дугараг алтан дээр хүний цээж дүрс, руни үсгийн хамт дүрсэлжээ. Дээл хувцасны хөдөлгөөн багатай хэсэгт хаддаг байсан бололтой дээр, доороо нэжгээд нүхтэй. Дугуй зураасны дотор талд 26 ширхэг үрлэн хээ, түүний дунд эгц харсан, хүний цээж дүрийг гаргажээ. Битүү хууз сахалтай, бөмбөгөр оройтой малгай өмссөн эсвэл толгойдоо тууз зангидсан, энгэрийг зөрүүлсэн хэлхгэр хувцас /нөмөрсөн/, унжуу зовхи бүхий бүлтгэр нүд, шулуун хамар, зузаавтар уруултай, хүзүүндээ эрхи мэт зүйл зүүсэн байдлаар дүрсэлжээ.

Уг чимэглэл VII зууны сүүл хагаст хамаарах Ираны зоосны дүрслэлтэй төстэй, түүний хуулбар байх бололцоотой. Хүний хөргийн хоёр талаарх бичээс нь 2 мөр болгон бичсэн 7 тэмдэгтээс бүрдэнэ.

ТОРСТЕН КЛАЙН БОЙНИНГ: АКТИВЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ БАНКУУДЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТУРШЛАГАД МАШ ТОМ ДЭВШИЛ АВЧИРСАН



ХасБанкны Эрдэл хариуцсан захирал, Монголын банкны холбооны дэд ерөнхийлөгч **ТОРСТЕН КЛАЙН БОЙНИНГТЭЙ** ярилцлаа.

2006.04–2008.05

Самба санхүүгийн нэгдэлд Эрсдэл хариуцсан ерөнхий менежерийн орлогч (Саудын Араб)

2008.05–2013.06

Эмират NDB банкны Актив ба багцын эрсдэл хариуцсан захирал (Дубай)

2013.07–2016.12

Стандарт чартеред банканд Засаглал, байгууллагын эрсдэлийн удирдлага хариуцсан захирал (Сингапур)

2017.01:

ХасБанкны Эрсдэл хариуцсан захиралаар ажиллаж байна.

Манай "Монголбанкны мэдээлэл" товхимлын Банкир буланд оролцож байгаа танд баярлалаа. Юун түрүүнд Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлын талаар яриагаа эхэлье.

-Миний бодлоор эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал харьцангуй таатай байна. Бид эдийн засгийн маш хүнд байдлаас гарч чадсан, түүнээс хойш амжилттай сэргэлээ. Манай банкны хувьд эерэг өөрчлөлтүүд, ялангуяа багц дээр багагүй ахиц гарлаа. Би энэ чиг хандлага 2018 оныг дуустал болон 2019 оны турш үргэлжилнэ гэж өөдрөгөөр харж байна.

Та ХасБанкинд 2017 оноос хойш Эрсдэл хариуцсан захирлаар ажиллаж байгаа. Мөн эрсдэлийн удирдлага тал дээр өндөр туршлагатай хүн. Банкны салбарт ихээхэн ахиц гарч, өмнөхөөс илүү тогтвортой болоод байгаа ч аливаа

салбарт үргэлж тодорхой эрсдэл оршсоор байдаг. Таны бодлоор Монголын банкны салбарт ямар эрсдэл оршиж байна гэж үзэж байна вэ?

- Тийм ээ, Би ХасБанкинд 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс ажиллаж эхэлсэн.

Банкны салбарын эрсдэлийн талаар ярих юм бол үл хөдлөх хөрөнгийн зах болон хэрэглээний зээлийн талаар онцлон ярих нь зүйтэй болов уу. Та бидний харж байгаачлан бүтээн байгуулалтууд эрчтэй явагдаж байгаа энэ цаг үед үл хөдлөх хөрөнгийн зах зээлд хэт нийлүүлэлт үүсээд байна. Мөн валютын ханшийн эрсдэл. Гэхдээ банкууд өмнөх түүхээс суралцсан гэдэгт итгэж байна.

ХасБанкны хувьд, бид харилцагчид ханшийн эрсдэлийн талаар идэвхтэй зөвлөж, гэрээний үндсэн дээр албадан хөрвүүлэлт хийх зэрэг чухал арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа. Ингэснээр бид

харилцагчдаа удирдаж, үл болох ханшийн эрсдэлээс хамгаалж байгаа юм. Тухайлбал, гадаад валютын ханш өсч тодорхой төвшинд хүрэх үед зээлийг төгрөг рүү шилжүүлж, харилцагчийн зээлийн эрсдэлийг хязгаарладаг.

Цаашлаад уул уурхайн салбарыг дурдахгүй өнгөрч болохгүй бөгөөд энэ салбар нь мөчлөгийн шинжтэй. Тиймээс өмнөх мөчлөгийн өөрчлөлтөөс банкууд сургамж авсан болов уу гэж найдаж байна. Энэ оны 10 дугаар сарыг авч үзвэл системийн чанаргүй зээлийн төвшин 12 хувьд хүрч өссөн нь өндөр өсөлт юм. Гэхдээ, мөн үед ХасБанкны чанаргүй зээлийн төвшин 5.3%-аар буурсан нь энэ хандлагаас эсрэг чиглэлд байна. Системийн чанаргүй зээл болон үүнтэй холбоотой эрсдэлүүдийг Монголбанк зохицуулж, арга хэмжээ авч чадна гэдэгт би итгэж байгаа. Тиймээс ч зах зээлд тогтворгүй байдал үүсэхгүй.

Банкуудад 2017 болон 2018 онд Активын чанарын үнэлгээг хийсэн. Энд онцолж хэлэхэд Монголбанк, цаашлаад Монгол Улсын бодлого тодорхойлогч нар энэхүү үнэлгээг хийснээр хэд хэдэн маш хэрэгтэй зохицуулалтыг бий болгосон. Үүнд арга хэмжээ авах, дахин хөрөнгөжүүлэх, үйл ажиллагаа доголдох үед тогтворжуулж, нөхөн сэргээх, чанаргүй зээлийг бууруулах стратеги хэрэгжүүлэх гэх мэт зохицуулалт багтаж байгаа. Эдгээр зохицуулалт нь хэрэгжсэнээр банкны салбар аливаа нөхцөл байдалд бүрэн бэлтгэлтэй байх юм.

ОУВС-ийн ажлын хэсэг Монгол Улсад ажиллаж, улирал тутам хийгддэг ээлжит үнэлгээг хийж дуусгасан. Тус үнэлгээний,

ажлын хэсгийн мэдэгдэлд банкны салбарын өөрийн хөрөнгө тал дээр эмзэг байдал оршсон хэвээр байна гэжээ. Үүнийг та хэрхэн үзэж байна вэ?

-Монгол Улсын банкны салбар, түүний чиг хандлага 3, 4 жилийн өмнөхөөс ихээхэн сайжирсан. Гэхдээ Активын чанарын үнэлгээ болон түүний үр дүнгийн талаарх олон нийтийн ойлголт, ухамсарлах өнцөг дээр маш болгоомжтой ажиллах хэрэгтэй. Энэ үйл ажиллагаан дээр Монголбанк маш тогтвортойгоор анхаарч байгаа гэж би үзэж байна.

Зээлийн өсөлт сүүлийн үед эрчимжлээ. Үүнийг дагаж эрсдэл хуримтлагдахаас сэргийлэн Монголбанкнаас шинэ үйл ажиллагааны чиглэл, макро зохистой бодлогын хүрээнд хэд хэдэн бодлогын шийдвэр гаргасан. Тухайлбал, иргэдийн хэрэглээний зээлийн өр орлогын харьцааг 70%-д, хугацааг 30 сараас хэтрүүлэхгүй байхаар тогтоож, 2019 оны 1 сарын 1-нээс мөрдүүлэхээр боллоо.

-Үүнийг хэрэглээний зээлийн хязгаарлалт гэж хэлж болно. Үнэнийг хэлэхэд гол зорилго нь хязгаарлахаас илүү хэрэглэгчийг хамгаалахад чиглэдэг. ХасБанк нь үргэлж хэрэглэгчийг хамгаалах зарчим бүхий олон улсын туршлага, бодлогыг дагадаг бөгөөд үүнийгээ гадны байгууллагаар үнэлүүлдэг. Тиймээс ч бид дотоод журмаараа өр-орлогын харьцааг 65%-д тогтоож, зээлийн эргэн төлөлтийн хугацааг 48 сараар хязгаарласан. Миний бодлоор эдгээр зохицуулалт, бодлогын арга хэмжээ нь иргэдийн зээл хэт их өсөхөөс сэргийлэхэд тустай.

Банкны салбарт эрсдэлийг сайн удирдаж чадсан нь илүү их өгөөж хүртдэг. Таны бодлоор өнөөг хүртэл Монголын банкны салбарын эрсдэлийн удирдлагын тогтолцоо хэрхэн хөгжиж байна вэ?

-Миний бодлоор саяхан хийгдсэн Активын чанарын үнэлгээ нь банкны салбарын эрсдэлийн удирдлагын туршлагад маш том дэвшил авчирсан. Энэ нь банкуудын барьцаа хөрөнгийн үнэлгээ, актив ангилал, тайлагнал зэрэгт дэвшил авчирч, олон улсын туршлагатай ойртуулж өгсөн. Хэдийгээр хүмүүс, тухайлбал би, АЧҮ-ний хэрэгжилт дээр гомдоллож байсан ч, энэ нь банкны салбарыг чадавхжуулж, сайн туршлагыг нутагшуулж чадсаныг хэлэх хэрэгтэй. Миний хувьд одоо сэтгэл хангалуун байгаа. ХасБанк ч энэ чиглэлийн туршлагыг хэрэгжүүлж байсан. Тиймээс тус үнэлгээ тийм ч их хүндрэлийг үүсгээгүй. Өдгөө чанаргүй зээлийг бууруулах стратеги, нөхөн сэргээх төлөвлөгөө зэрэг шинэ зохицуулалт нь сайн туршлагыг авчирна гэж харж байна. Хэрвээ надад хүсэх зүйл байгаа бол Монголбанк гүйцэтгэлд суурилсан сэтгэлгээнээс эрсдэлд суурилсан сэтгэлгээ бүхий зохицуулалтад шилжих нь чухал юм.

Энд ярихгүй өнгөрч болохгүй өөр нэг сэдэв бол актив удирдлагын компани. Актив удирдлагын компани нь эрсдэлийн удирдлагад томоохон давуу талыг бий болгодог. Гэхдээ үүн дээр бага зэрэг зөрүүтэй байр сууриуд ажиглагдах боллоо. Та үүнийг хэрхэн харж байна вэ?

-Актив удирдлагын компанийг

бие даасан арга хэмжээ гэхээс илүү томоохон бүтцийн нэг хэсэг гэдгийг ойлгох нь зүйтэй болов уу. Чанаргүй зээлийг шийдвэрлэхийн тулд хэд хэдэн арга хэрэгсэл хэрэгтэй.

Юун түрүүнд эрсдэлийн сан байгуулах, актив ангилал хийх хэрэгтэй. Банкууд эрсдэлийн сан, актив ангиллаа зүй зохистой бөгөөд цаг тухайд нь байгуулж байх хэрэгтэй. Хоёрдугаарт хууль эрх зүйн тогтолцоо байгаа. Үүнд актив удирдлагын компани, компаний өрийн бүтцийн өөрчлөлтийн хороо буюу тогтолцоо зэрэг багтана. Компаний өрийн бүтцийг өөрчлөлтийн хороо нь чанаргүй зээл, актив нь актив удирдлагын компанид шилжихээс өмнө арга хэмжээ авах бүтэц, үйл ажиллагаа юм. Энэ тал дээр Азийн хөгжлийн банк Монголын арилжааны банкуудтай хамтран ажиллаж байсан. Гуравдугаарт, хийвэл зохих зүйл бол дампуурлын тухай хууль, буюу хамгаалалт юм. Техникийн хувьд харилцагч дампуурах үед банкууд хэзээ арга хэмжээ авч, төлөгдөхгүй болсон зээлийн барьцаа хөрөнгийг мэдэлдээ авах нь тодорхой байх хэрэгтэй.

Актив удирдлагын компанийг тухайлан авч үзвэл хэд хэдэн боломжууд байгаа. Олон Улсын туршлагад актив удирдлагын компани нь тус дэмтэй хэрэгсэл болж ирсэн. Үүнд Малайз, Индонез, Герман, БНХАУ зэрэг улсын жишээг дурдаж болно. Тэр дундаа БНХАУ нь маш сонирхолтой жишээ. Учир нь БНХАУ-д чанаргүй зээл Актив удирдлагын компанид шилжээд 10-аас олон жил болдог.

Тэгэхээр банкуудын балансаас яагаад чанаргүй зээлийг авах ёстой юм бэ гэсэн асуулт гарна. Банкны

салбараас харахад санхүүгийн зах зээлийн дийлэнх чанаргүй зээл нь эдийн засгийн өмнөх хүндрэлээс үүдэн гарч ирсэн байгаа. Тэгэхээр тэдгээр нь аль хэдийн 2-3 жилийн настай гэсэн үг. Монгол Улсын эдийн засаг нь мөчлөгийн бөгөөд дараагийн хямрал болох үед чанаргүй зээлийн хэмжээ бүр их хуримтлагдаж, илүү их хүндрэлийг бий болгоно. Үүн дээр шүүх тогтолцооны ч дэмжлэг байх хэрэгтэй. Учир нь өнөөгийн байдлаар актив, барьцаа хөрөнгийг шийдвэрлэхээр шүүх дээр очиход 3-5 жилийн хугацаа шаардаж байна. Бүр зарим тохиолдол шүүхийн шийдвэрийг албадан хэрэгжүүлэх боломжгүй байна.

Актив удирдлагын компани нь төрийн өмчит байвал зохимжтой юу эсвэл хувийн өмчийнх байвал дээр үү?

- Аль аль нь боломжтой учраас аль нэгийг нь би онцлохгүй. Хэрэв төрийн өмчит актив удирдлагын компани байгуулвал санхүүжилтийн эх үүсвэр нь янз янз байх боломжтой. Гэхдээ татвар төлөгчдийн мөнгөөр санхүүжигдэхгүй байвал зохино. Хэрэв чанаргүй активыг 10-15 жил байлгабал инфляци өөрөө шийдлийг олоход дэмжлэг болдог. Хамгийн гол нь тэдгээр чанаргүй активыг банкуудын балансаас авч эргэлтэд оруулах хэрэгтэй. Улсын дундаж инфляци 5-8 хувь байх үед цаг хугацаа бол хамгийн том холбоотон юм.

Бидний бүх анхаарлыг шаардсан өөр нэг томоохон эрсдэл бол Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хүрээний асуудлууд юм. Манай улс 2017 онд APG байгууллагаас энэ тогтолцоог



сайжруулах зөвлөмж, үүрэг авсан. Өдгөө хууль эрх зүйн тогтолцоонд маш том ахиц гарсан. Гэхдээ нөгөө талд хэрэгжилт болон дагаж мөрдөх тал дээр хэр ахиц гарсан гэж үзэж байна вэ?

-Юун түрүүнд би Монголын Засгийн газар болон донор орон, салбарын хамтарсан хүчин чармайлтад маш их талархаж буйгаа хэлэх хэрэгтэй. Би банкны салбараас зохион байгуулсан "Комплаенс Форум"-д хоёр дахь жилдээ оролцсон. Тэнд оролцож байхад банкны салбар, бодит салбар, хяналт шалгалтын байгууллагууд, бодлого тодорхойлогч нарын зүгээс ихээхэн ахиц гаргасан болохыг анзаарсан. Монгол Улсад мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо, арга хэмжээг чадавхжуулахын тулд APG-ийн харилцагчаа таниж мэдэх материал зэрэг маш олон зүйл чухал.

Нэгдүгээрт өөр өөр байгууллага, зах зээлд оролцогчид мэдээллийг хуваалцах тухай. Одоогийн байдлаар банкууд мэдээллийг зөвхөн хяналт шалгалтын байгууллага Монголбанкттай л хуваалцаж байгаа. Гэхдээ нөгөө талаас мэдээлэл мөн нийлүүлбэл

бид илүү их хурдтай, үр дүнтэй, тодорхой ажиллаж, арга хэмжээ авах боломжтой.

Хоёрдугаарт, хяналт шалгалтын эрсдэлд суурилсан зарчим бол маш чухал. Монголчуудын буюу банкны салбарын харилцагчдын 97% нь сайн хүмүүс. Гэхдээ бусад оронтой адил хүндрэл учруулдаг харилцагчид байдаг ба энэ нь үлдсэн 3% юм. Өнөөгийн хяналт шалгалтын зарчим, үзэмжээр, бүх харилцагчдад ижил ханддаг ба энэ үед маш их цаг хугацаа, зардал, хүчин чармайлт, анхаарал, яриа хэлэлцээр шаардаж байна. Тиймээс түрүүн хэлсэнчлэн Төв банк эрсдэлд суурилсан зарчимд шилжих нь зүйтэй юм. Банкууд 97%-ийг харахаас илүү тэрхүү 3% дээр илүү их анхаарал хандуулбал зохино.

Өөр нэг чухал асуудал бол бид банкны салбар болон банкнаас бусад санхүүгийн зах зээлийн комплаенс дээр ижил төвшинд анхаарах хэрэгтэй. Одоогийн байдлаар банк бус санхүүгийн байгууллагууд, хуульчид, үл хөдлөх хөрөнгийн брокер зэрэг оролцогчид харилцан адилгүй төвшинд комплаенсийг хангаж байна. Эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэхийн тулд тэдгээрийг банктай ижил төвшинд авчрах хэрэгтэй. СЗХ-ны хүчин чармайлтад баяртай байгаа ч илүү их хурдтай, нямбай ажиллах хэрэгтэй болов уу.

Гурав дахь чухал зүйл бол бид гадны клиринг банк болон бусад банкуудтай харилцаж байх үед улс төрд нөлөө бүхий этгээд (УТНБЭ), эцсийн өмчлөгч гэсэн ойлголтуудыг тодорхой болгох нь чухал. Бусад жишгээс харахад Засгийн газраас УТНБЭ-ийн нэрсийн жагсаалтыг гаргаж, банкууд үйл ажиллагаандаа

ашигладаг.

Өөр нэг онцлох ойлголт бол эцсийн өмчлөгч. ХасБанкны хувьд бид үүнийг маш чухлаар хүлээж авдаг. Болгар Улсын жишээн дээрээс харахад компанийн бүртгэлийг багтаасан олон нийтэд нээлттэй дата сан байдаг. Би аль нэг компанийн регистрийн дугаар хийвэл хамаарал бүхий этгээд, эзэмшигч, эцсийн эзэмшигч, шүүхийн шийдвэр — тохиолдлууд гээд өргөн хүрээний мэдээллийг авах боломжтой. Энэ нь Засгийн газраас үзүүлдэг нээлттэй үйлчилгээ бөгөөд гол гайхамшиг нь банкуудын ажлыг маш их хөнгөвчилдөг. Энэ нь зардлыг хэмнэж, харилцагчийн төлөх шимтгэл, бичиг цаасны ажлыг багасгадаг. Мөн энэ нь банкуудын мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг өндөр төвшинд хадгалдаг. Одоогийн байдлаар Монголын банкууд мэдээллийг тухайн компаниас авдаг нь тийм ч оновчтой биш.

Эцэст нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа арга хэмжээнийхээ талаар илүү их танилцуулж, олон улсад мэдээлж байх хэрэгтэй болов уу. Миний ажиглалтаар бид нэг бол хэтэрхий даруухан байна, эсвэл хэрхэн илэрхийлэх ээ мэдэхгүй байх шиг байна. Энд аль нэг нь гэлтгүй санхүүгийн салбар, хууль эрх зүйн зэрэг албан салбар, хяналт шалгалтын байгууллагууд нь бүгд хамтарч нэг чиглэлд ажиллавал эерэг үр дүнд хүрнэ. APG-ийн тайланд Монгол Улсыг сайнгүй бичсэн боловч үнэндээ нөхцөл байдал тийм ч муу биш байгаа.

Манай ярилцлагын эхний хэсэг ийнхүү өндөрлөж байна. Хоёр

дахь хэсэгт таны талаар болон таны мэргэжлийн талаар ярих болно. Таны овгоос харахад Та Герман хүн бололтой. Та Германы аль хэсэгт төрж өссөн бэ?

-Би ХБНГУ-ын баруун хойд хэсэгт орших, Мьюнстер хотод төрсөн. Энэ салбарт одоо 20 гаруй жил ажиллаад байна.

Өмнө нь би Сингапур дахь “Стандар Чартерд” банкинд ажиллаж, Олон улсын тайлагналын 9 дүгээр стандартын загвар, стресс тест зэрэг эрсдэлийн засаглал, комплаенсийн загварууд дээр ажиллаж байсан. Түүнээс өмнө Ойрхи Дорнодын хамгийн том банкуудын нэг “Эмират NBD” банкинд Дубай хотноо ажиллаж байсан. Миний бие тэнд 2008 оны үл хөдлөх хөрөнгийн хямралын дараахан хөрөнгийн багц удирдах багийн гишүүнээр ажилласан. Тиймээс тэнд харж, туулж байсан зүйлс маань энд ч давтагдаж байна.

Түүнээс өмнө би Саудын Араб дахь “Сауд Америкийн банк” буюу Самба (хуучин Citi банкны нэгдэлд багтдаг байсан) нэртэй банкинд ажиллаж байсан. Мөн би Австри Улсад Базелийн II-р стандартын 11 улс дахь хэрэгжилтийг хариуцан ажиллаж байлаа. Тэнд л би банкны салбарт татагдан орсон. Миний ажлын түүхийг харвал би Олон Улсын Санхүүгийн Институттэй тун ойр ажилласан. Энэ нь дэлхийн банкуудын томоохон ассоциаци юм. Мөн би Базелийн хороотой хамтран ажлын хэсэгт орж эрсдэлээр жигнэсэн актив, эрсдэлийн загварууд дээр ажиллаж байлаа.

Өдгөө би Монгол Улсад хэд хэдэн албан тушаалыг зэрэг хашиж байна. Нэгдүгээрт, хамгийн том ажил маань ХасБанкны Эрсдэл хариуцсан захирал. Маш сонирхолтой ажил. Түүнчлэн, би Тэнгэр Санхүүгийн Нэгдэлд эрсдэл хариуцан ажиллаж байна. Мөн надад итгэл хүлээлгэсэн тул Монголын банкны холбоонд дэд ерөнхийлөгчөөр комплаенс, хууль эрх зүй, кибер эрсдэл зэргийг анхааран ажиллаж байгаа. Цаашлаад DMUV буюу Герман, Монголын бизнес эрхлэгчдийн холбооны удирдах зөвлөлд сууж байгаа.

Монголд ажиллах надад таалагддаг. Монгол сайн сайхан руу хүрэх өөрчлөлтийг хийх боломжтой улс. ХасБанкны ажилтнууд хэдий залуу ч тэд надад сэтгэгдэл төрүүлсэн. Тэд шинийг сурахыг, сайнаар өөрчлөгдөхийг хүсэж эрмэлздэг. Нөгөө талаас удирдлагын багт маш их эрч хүчтэй, нээлттэй сэтгэлгээтэй хүмүүс багтдаг.

Та яагаад банкны салбарыг сонгож, эрсдэл талыг хариуцдаг болсон бэ?

-Үнэнийг хэлэхэд би банкны салбарт санамсаргүй орсон. Угтаа бол би ажлын гараагаа мэдээллийн технологийн зөвлөхөөр эхэлсэн. Би Америкт төвтэй консалтинг компанид дата сан байгуулах, дата төв сонгох гэх мэт ажлыг хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байсан. Улмаар би үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагааны эрсдэл, түүний дата санг хөгжүүлэх ажлыг хийж байсан. Германы Дресднер Банк буюу тухайн үеийн хамгийн нэр хүндтэй банк манай үйлчлүүлэгч байсан, тэдний үйл ажиллагааны эрсдэлийн загварыг баталгаажуулах нэр хүндтэй ажил

надад ногдсон юм. Ингэснээр би үйл ажиллагааны эрсдэл рүү орсон нь надад маш их таалагдсан. Тэнд надад Австри Улс руу явах боломж гарч Базел II-ийн хэрэгжилтийг зохицуулах ажилд очсон. Тогтолцоо, загвар, үйл ажиллагаа, хэлэлцээрт оролцогчидтой хийх харилцаа гээд маш олон зүйл дээр ажилласан. Тэнд л эрсдэлийн удирдлага хэмээх зүйлд би халтирч орсон юм даа.

-Эрсдэлийн удирдлага нь банкинд тээр болохгүй, харин ч дэмжлэг үзүүлэх ёстой зүйл. ХасБанк нь “Хамгаалалтын 3 бүс” хэмээх үзэл баримтлал – концепцыг ашигладаг.

Газар нэгжүүд өөрсдийн эрсдэлийг хянаж, зохицуулах нь эхний бүс. Хоёрдугаарх бүс бол, эрсдэлийн удирдлагын тогтолцоо, бодлого, журам зааврыг боловсруулах ажил багтана. Энд эрсдэлийн удирдлагын хяналтыг хийж бизнесийн үйл ажиллагаа зохих хил хязгаарыг давахгүй, эсвэл бидний зүгээс тэдэнд өгсөн зөвлөмжийн дагуу ажиллаж байна уу гэдгийг анхаардаг. Гурав дахь бүс бол хараат бус аудит хийлгэж, нэг болон хоёрдугаар хамгаалалтын бүс зүй зохистой ажиллаж байна уу гэдгийг хянадаг. Мөн Удирдах зөвлөл нь дэргэдэх дотоод аудитын нэгжээс хараат бус баталгаажуулалт авдаг. Эрсдэлийн үйл ажиллагаа нь тогтвортой ашгийг бүрдүүлэхийн тулд эрсдэлийг зохистой удирдах явдал юм.

Та залуу банкируудад ямар зөвлөгөө өгөх вэ?

- Надад 3 зөвлөгөө байна.

Юун түрүүнд, нээлттэй бай. Залуучууд хайрцаглагдаж, зөвхөн хий гэснийг хийдэг сэтгэлгээтэй

байж болохгүй. Чи өөрийгөө юу хийх болон хийж чаддагаа ойлгосон байх хэрэгтэй.

Хоёрдугаарт, хэрэв чи банкны салбарт ажиллах гэж байгаа бол харилцагчийн сэтгэхүй - менталитиг ойлгосон байвал зохино. Учир нь харилцагч, хэрэглэгч гэдэг чинь л банкныг бий болгож байгаа. Дүрэм журам, зааврыг би болгосноор чи 100% эрсдэлгүй ажиллаж болох ч, нөгөө талд харилцагчдын тоо цөөрөх аюултай. Тиймээс харилцагчийн сонирхол болон банк, түүний хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх хэрэгтэй.

Эцэст нь эрсдэлээс битгий ай. Учир нь банкны бизнес гэдэг бол эрсдэлийг удирдах урлаг юм. Хэрэв эрсдэл байхгүй бол тэнд хүү төлөхгүй. Кредит гэдэг үгний утга нь өөрөө “Итгэх” юм. Тиймээс тэнд үргэлж тодорхойгүй байдал, зээл эргэн төлөгдөхгүй байх аюул оршоор байдаг тул алдагдлыг удирдаж, энэ бүхнийг хийж эрсдэлийг хүлээж авсныхаа хариуд шагнагдаж байх ёстой.

Нөгөө талаас таныг залуу байхад танд өгч байсан хамгийн сайхан зөвлөгөө юу байв?

- Намайг Германд ажиллаж байхад тухайн үед миний дарга байсан хүн “Сайн гэдэг бол хангалттай гэсэн үг биш, чи илүү сайн байх хэрэгтэй” гэж байсан. Мөн “Хэцүү хэмээх шалтгаар хэзээ ч битгий ажлаас хойш сууж бай” гэж байсан.

Сайхан зөвлөгөө байна. Ийнхүү бидний ярилцлага дуусч байна. Цаг заваа гарган ярилцсанд баярлалаа.



МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ БОДЛОГОД АНХААРАХ АСУУДЛУУД

Монголбанкнаас улирал бүр эрхлэн гаргадаг "МӨНГӨ-САНХҮҮ-БАЯЛАГ" сэтгүүлийн найм дахь дугаараас онцлов.

Л.Даваажаргал¹, О. Цолмон², Б.Хүслэн³, Г.Мөнхбаяр⁴, Д.Ган-Очир⁵

ХУРААНГУЙ:

Сүүлийн жилүүдэд Монгол улсын худалдааны салбарын эзлэх хувь боловсруулах салбарын эзлэх хувиас хоёр дахин их болсон хэдий ч Монгол улсад гадаад худалдаа хийх орчин, нөхцөл хангалтгүй; худалдааг дэмжих, хөнгөвчлөх үйл ажиллагаа дутмаг; гадаад худалдааны иж бүрэн, нэгдсэн бодлогогүйгээр явж иржээ. Иймд гадаад худалдааг хөгжлийн бодлогын нэг тулгуур болгож амжилттай хэрэгжүүлж ирсэн бусад улсын адил Монгол улсад гадаад худалдааны бодлогыг шат дараатай, тогтвортой хэрэгжүүлэх гадаад худалдааг хариуцсан яам /агентлаг/ байгуулах шаардлагатай байна. Гадаад худалдааг дангаар хариуцах яам /агентлаг/ бий болсноор төлбөрийн тэнцэл, гадаад валютын нөөц сайжрах, эдийн засагт бүтцийн өөрчлөлт хийгдэх, үр ашиг нэмэгдэх зэрэг ач холбогдолтой.

МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ БОДЛОГЫН ТҮҮХ

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үеийн гадаад худалдаа: Манай улсын гадаад худалдаа 1920-1960-аад оны үед зөвхөн Зөвлөлт Холбоот Улс (ЗХУ) руу чиглэсэн бүтэцтэй байсан бол 1960-аад оноос 1990-ээд он хүртэл Эдийн Засгийн Харилцан Туслах Зөвлөлийн (ЭЗХТЗ) хүрээгээр хязгаарлагдаж байлаа. Эдгээр он жилүүдэд гадаад худалдааны нийт эргэлтийн 90 орчим хувийг ЗХУ болон ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудтай хийсэн худалдаа бүрдүүлж байв. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед худалдааны салбарыг чухал ач холбогдолтой салбар хэмээн үзэж тухайн цаг үеийн нөхцөл байдал, онцлогт тохируулсан худалдааны асуудал эрхэлсэн төрийн байгууллагыг ажиллуулж байжээ. Түүнчлэн, гадаад худалдааг чухалчлан үзэж худалдааны төрийн байгууллагын дэргэд дэлхийн болон түнш орнуудын багтаамж, зах зээлийн үнэ, бүтээгдэхүүний үйлчилгээний нэр төрлийн талаар судалдаг хүрээлэнг ажиллуулж байв (Т.Аюурсайхан, 2014).

Чөлөөт зах зээлийн үеийн гадаад худалдаа: ЭЗХТЗ 1991 оны 6 дугаар сард албан ёсоор татан буугдсан.

Ингэснээр ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудтай хийсэн худалдаа 1989 онд 90 хувь байсан бол 1992 онд 57 хувь болж огцом буурч, манай улс Европт ХБНГУ, Швейцарь, Итали, Франц, Их Британи, Азид Япон, БНСУ зэрэг улстай гадаад худалдаа хийж эхэлсэн. Түүнчлэн, Монгол улсын хувьд гадаад зах зээлд гаргах байр сууриа үндсээр нь өөрчлөх шаардлагатай тулгарсан. Өрсөлдөөн ихтэй зах зээл дээр худалдааны шинэ түншүүдийг олох, гадаад зах зээлд нэвтрэх шаардлагатай болсон тул Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-д 1997 оны 1 дүгээр сард элссэн. ДХБ-ын гишүүн орон болсноор Монгол улс дэлхий зах зээлд нэвтрэх илүү таатай, найдвартай гарц үүссэн бөгөөд олон талт хамтын ажиллагааны хүрээнд бусад улс оронтой хамтран худалдааны зорилтуудыг биелүүлэх боломж бүрдсэн.

МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ БОДЛОГЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол улсын эдийн засгийн бүтэц: Цэвэр экспорт (экспорт, импортын зөрүү) нь гадаад худалдааны тэнцлийг илэрхийлэх бөгөөд нийт эдийн засаг болон түүний өсөлтөд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тухайлбал, Монгол улсын хувьд цэвэр экспортын өсөлтийн хувь нь ДНБ-ийн өсөлтийн хувьтай өндөр хамааралтай байдаг.

¹ Монголбанкны Судалгаа, статистикийн газрын Судалгааны хэлтсийн захирал.

² Монголбанкны Судалгаа, статистикийн газрын эдийн засагч.

³ Монголбанкны Судалгаа, статистикийн газрын эдийн засагч.

⁴ Монголбанкны Судалгаа, статистикийн газрын эдийн засагч.

⁵ Монголбанкны Судалгаа, статистикийн газрын захирал.

Цэвэр экспорт нь валютын ханш, ерөнхий хүүний төвшин болон хөрөнгийн зах зээлийн хөгжил зэрэгт тодорхой нөлөө үзүүлж байдаг. Өөрөөр хэлбэл, тухайн улсын гадаад худалдааны оновчтой бодлого болон эдийн засгийн өсөлт, хөгжилд чухал нөлөө үзүүлдэг.

Монгол улсын экспорт, импорт цаашид өсөх хандлагатай байгаа тул гадаад худалдааны эргэлт нь ДНБ-ий дунд хугацааны өсөлтөд томоохон нөлөө үзүүлэхээр байна. Иймд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах хүрээнд гадаад худалдааны оновчтой бодлоготой байх нь тулгамдаж буй чухал асуудал болж байна.

Эдийн засгийн салбарын бүтцийг авч үзвэл сүүлийн 7 жилийн хугацаанд худалдааны салбарын эзлэх хувь боловсруулах үйлдвэрлэлийн салбарын эзлэх хувиас 2 дахин их байгаа нь бизнес эрхлэгчдэд үйлдвэрлэлээс илүүтэй худалдаа эрхлэх хандлага байгааг илэрхийлнэ.

Дэмбэрэл¹ (2005) нь Монгол улсын хөгжлийн чиг хандлагыг “5Ц+ХҮ” гэж томъёолсон. Үүнд “худалдаачин үндэстэн” гэж тухайн орны эдийн засгийн өсөлт, хөгжлийн гол хүчин зүйл нь худалдааг бий болгож чадсан, гадаад худалдааг ашигтайгаар хийж чаддаг улс гэж хялбаршуулан тодорхойлж болно. Монгол улсын эдийн засагт гадаад худалдаа чухал үүргийг гүйцэтгэдэг учир гадаад худалдааг үр ашигтай хийж чаддаг “худалдаачин үндэстэн” болох замаар эдийн засгийн өсөлтийг дэмжих шаардлага манай оронд тулгарч байна.

Гадаад худалдааны бодлогын өнөөгийн нөхцөл байдал: Манай улсын хувьд гадаад худалдааг зохицуулсан тухайлсан хууль, гадаад бодлогын талаар баримтлах төрийн бодлого байхгүй учраас гадаад худалдааны үйл ажиллагаанд оролцогч талуудыг хамруулсан нэгдсэн мэдээллийн сан одоогоор байхгүй байна (Б.Батчимэг, 2018).

Манай улсын засгийн газраас сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд эдийн засгийг төрөлжүүлэх, тэр дундаа уул уурхайн бус салбарын экспортыг бодитой дэмжих цаашлаад экспорт, импортын нэгдсэн тогтолцоог

бий болгох зорилтын хүрээнд олон бодлого, хөтөлбөр баталсан хэдий ч үр дүнтэй, биелэлт сайтай бодлого, хөтөлбөр алга байна. Энэ нь манай улс худалдааны нэгдсэн бодлогогүй, бодлого боловсруулалт, хэрэгжилтийг хариуцсан газар байдаггүйтэй холбоотой юм.

Монгол улсад гадаад худалдааг дангаар нь хариуцдаг яам байхгүй, одоогоор Монгол улсын гадаад худалдааны бодлогыг Гадаад харилцааны яамны “Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газар” хариуцан ажиллаж байна.

Олон улсын хамтын ажиллагаа

А. Худалдааны гэрээ хэлцэл

Монгол улс ДХБ-д нэгдсэнээс хойш хоёр улсын хамтын худалдааны дараах цөөн хэдэн хэлэлцээрүүдийг хийсэн байна.

Хүснэгт 1 | ДХБ-д нэгдсэнээс хойших хоёр улсын хамтын худалдааны хэлэлцээр

Хэлэлцээр	Огноо	Тайлбар
Европын эдийн засгийн нийгэмлэг болон Монгол Улсын засгийн газар хоорондын нэхмэлийн салбар дахь худалдааны гэрээ	1997/12/31	Монголын оёдлын бүтээгдэхүүнийг дэмжих
Вьетнам болон Монгол Улсын засгийн газрын хоорондох худалдааны гэрээ	1999/12/13	Худалдаа, тээвэр, соёлын салбарт хамтран ажиллах
Куба болон Монгол Улсын засгийн газрын хоорондох худалдааны гэрээ	2001/09/11	2 улсын хоорондын худалдаанд нэмэлт худалдааны хязгаарлалт хийхгүй байх тухай
АНУ болон Монгол Улсын засгийн газрын хоорондох худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны гэрээ	2004/05/15	Хамтын худалдаа, хөрөнгө оруулалтын консул байгуулж, 2 улсын цаашдын худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжин ажиллах
АНУ болон Монгол Улсын засгийн газрын хоорондох олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын хэлэлцээр	2013/09/24	Худалдаанд сөргөөр нөлөөлж буй саадыг арилгах талаар санал солилцох
Эдийн засгийн тухай Монгол-Японы хоорондын хэлэлцээр	2015/2 сар	Эдийн засгийн хэрэгцээ, шаардлагыг харгалзан эдийн засаг болоод худалдаанд түлхэц үзүүлэх

¹ С.Дэмбэрэл, Эдийн засгийн шинэтгэл ба хөгжил, 2005 (5Ц нь цэвэр байгаль орчин, цэвэр хүнс, цэвэр үйлдвэрлэл, цэгцтэй мэдлэг буюу цэгцтэй боловсрол, цахим нийгэм буюу ХҮ нь “Худалдаачин үндэстэн” /Trading nation/-ий товчлол юм.)

Эх сурвалж: (WTO, 2014)

Дээрх хэрэгжүүлж буй хамтын ажиллагаанаас өөр төрлийн олон улсын гадаад худалдааны хамтын ажиллагаа Монгол улсад одоогоор алга (Гадаад харилцааны яам, 2018).

Б. Худалдааны чөлөөт бүс, хил орчмын худалдаа

Далайд гарцгүй Монгол улсын хувьд хил орчмын худалдааг хөгжүүлэх нь чухал. Иймээс хил гаалийн дүрэм, журмыг цэгцтэй болгох, хяналт, хураамжийг багасгах зэрэг хил орчмын худалдааг хөнгөвчлөх шаардлага тавигддаг. Энэ нь гадаад худалдааг дэмжих, хил орчмын бүс нутгийг хөгжүүлэх, оршин суугчдын амьжиргааг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Хил орчмын худалдааг дэмжих нэг гол хэлбэр нь эдийн засгийн тусгай бүс (Худалдааны Чөлөөт бүс) байгуулах асуудал байдаг.

Засгийн газар эдийн засгийн болон худалдааны чөлөөт бүсийг 4 газарт (Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сум, Дорноговь аймгийн Замын-Үүд, Баян-Өлгий аймгийн Цагаан нуур болон Говьсүмбэр аймгийн Баянтал сум) байгуулахаар шийдвэрлэсэн. Гэвч одоогийн байдлаар аль ч бүс үйл ажиллагаа бүрэн явуулж эхлээгүй байна. Монгол улсад Чөлөөт худалдааны бүсийн үйл ажиллагаа хангалтгүй, тааруу байна гэж дүгнэж болохоор байна.

ГАДААД ХУДАЛДААНЫ БОДЛОГЫН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ, АЧ ХОЛБОГДОЛ

Гадаад худалдааг дэмжих, хөнгөвчлөх үйл ажиллагаа:

Худалдааны бодлогыг хэмжих чухал үзүүлэлт болох гадаад худалдааны үйл ажиллагааг дэмжих, хөнгөвчлөх үйл ажиллагаа Монгол улсад хэр төвшинд байгааг Дэлхийн банкны тооцдог индексүүдийг ашиглаж бусад орнуудтай харьцуулав. Логистикийн гүйцэтгэлийн индекс, бизнес эрхлэлтийн ерөнхий индекс болон хил дамнасан худалдааны үзүүлэлтээс харахад манай улсын гадаад худалдаа эрхлэх үйл ажиллагаанд олон тооны бичиг баримт, бүрдүүлэлтэд шаардагдаж буй техникийн саад тотгорууд, төрийн байгууллагын хүнд суртал, хууль эрх зүйн орчны ил тод бус байдал зэрэг сөрөг хүчин зүйлс нь бүхэлдээ зардлыг нэмэгдүүлж, экспорт, импортын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

Тухайлбал, логистикийн гүйцэтгэлийн индексээр манай улс бүс нутгийн улс орнууд, хөрш зэргэлдээ орнуудтай харьцуулахад доогуур үзүүлэлттэй байна. Тодруулбал 2018 оны логистикийн гүйцэтгэлийн индексээр манай улс дэлхийн 160 орноос 130 дугаар байранд буюу 2016 оны үзүүлэлтээс 22 байраар ухарсан байна. Бизнес эрхлэлтийн индексээр 2018 онд 190 орноос 62 дугаар байрт жагссан бол

гадаад худалдааны үйл ажиллагааг илтгэх хил дамнасан худалдааны үзүүлэлтээр 110 дугаар байрт жагсаж өмнөх оноос 7 байр ухарсан байна.

Гадаад худалдааны бодлогын нөлөөллийн үзүүлэлтүүд:

Дараах гадаад худалдааны бодлоготой холбоотой макро үзүүлэлтүүдийн нэгтгэлээс манай улсын гадаад худалдааны бодлогын идэвхжилт, хэрэгжилт болон үр дүн тун хангалтгүй байгааг дүгнэж болохоор байна. Үүнд:

Урсгал тэнцлийн алдагдал:

Монгол улс сүүлийн 10 жилийн 9 жилд нь урсгал тэнцлийн алдагдалтай байжээ. Олон жил дараалан худалдааны алдагдалтай явах нь эдийн засгийн гэнэтийн шокуудад илүү өртөмтгий байх хандлагатай байдаг. Тухайлбал, гадаад өрийн өсөлт, хүүний өсөлт болон капиталын зугааалт зэрэг нь санхүүгийн хямралыг бий болгох эрсдэлтэй юм. Иймээс урсгал тэнцлийн алдагдлыг бууруулах, түүнд чиглэсэн худалдааны бодлогыг оновчтой хэрэгжүүлэх явдал чухал байна.

Экспортын төвлөрөл: Монгол улсын экспортын төвлөрөл маш өндөр байна. Экспортын бүтээгдэхүүний төрөлжилт өндөр байх тусам тухайн улсын гадаад худалдааны орлогын эрсдэл буурдаг бөгөөд нэг салбараас хэт хамааралтай эдийн засагтай байх аюулаас ангид байдаг. Харин байгалийн баялаг ихтэй хөгжиж

буй орнуудын экспорт нь хэт нэг салбар дээр тулгуурласан байдаг тул эдийн засаг нь гадаад шоконд хэт өртөмтгий болдог. Өмнөд Солонгос, Хятад болон Чили зэрэг экспортын орлогоор тэргүүлэгч орнуудын гадаад худалдааны бодлогын нэг том концепц нь экспортын төрөлжилт байдаг. Тухайлбал, Уганда улс гадаад худалдааны бодлогоо экспортыг төрөлжүүлэхэд чиглүүлэн, экспортыг төрөлжүүлэх стратеги хэрэгжүүлэн ажиллаж байна.

Худалдааны гэрээ хэлцэл:

Худалдааны гэрээ хэлцэл нь гадаад худалдааны бодлогын чухал хэрэгсэл болох ёстой бөгөөд худалдааны гэрээ хэлцлийг хөгжингүй орнуудад өргөнөөр ашигладаг бол ихэнх хөгжиж буй орнуудад тэр бүр ашиглаж чаддаггүй байна. Монгол улсын хувьд худалдааны гэрээ хэлцлийг тэр бүр ашигладаггүй нь нөгөө талаар Монгол улсын гадаад худалдааны бодлогын идэвхжил дутмагтай холбоотой юм.

Худалдааны хамгаалалт:

Монгол улс худалдааны хамгаалалтын арга хэрэгслийг идэвхтэй хэрэглэдэггүй. Энэ нь худалдааны нээлттэй байдалд эерэг нөлөөтэй хэдий ч үндэсний аюулгүй байдал алдагдах, зарим орны худалдаанаас хэт хараат байдалд орох эрсдэлийг дагуулдаг. Улс орнууд гадаад худалдааны бодлогодоо хамгаалалтын

хэрэгслүүдийг тусгаж өгдөг бөгөөд шаардлагатай тохиолдолд тодорхой хэмжээгээр хэрэгжүүлдэг билээ.

Гадаад худалдааны бодлогын орон зай: Монгол улсад 2016 оны байдлаар гадаад худалдааны бодлогын орон зай хязгаарлагдмал байгаа хэдий ч хөгжингүй болон Европын орнуудтай харьцуулахад харьцангуй их ажээ. Иймд манай орны хувьд гадаад худалдааны бодлогыг оновчтой тодорхойлох, үр дүнтэй бодлого гаргахыг эрмэлзсэн тохиолдолд хэрэгжүүлэх бодлогын орон зай тодорхой хэмжээнд байна.

Валютын ханшийн өөрчлөлт:

Монгол улсын төгрөгийн доллартай эсрэг харьцах ханш 2010-2016 оны хооронд эрс суларчээ. Гадаад худалдааны бодлогыг оновчтой тодорхойлж, амжилттай хэрэгжүүлсэн тохиолдолд валютын ханш тогтвортой байх боломж бүрдэнэ.


Улс орнуудын гадаад худалдааны бодлогыг хариуцдаг нэгж:

Олон улсын төвшинд улсын гадаад худалдааг хариуцдаг яамдыг нийт 205 орны хувьд судаллаа. Улсуудын дийлэнх нь буюу 95% (195 улс) нь худалдааны яамтай, үүний дотор 25% нь (51 улс) гадаад худалдааг дангаар хариуцан ажилладаг яамтай байна. Харин нийт улсын 5% нь (11 улс, үүнд Монгол улс орно) гадаад худалдааг шууд ариуцсан яамгүй буюу гадаад харилцааны яам нь уг бодлогыг

хариуцан ажиллаж байна.

Олон улсын туршлага: Өмнөд Солонгос, Чили, Хятад зэрэг худалдааны бодлогоор импортыг орлуулж, экспортыг нэмэгдүүлж, төрөлжүүлэх улмаар эдийн засгийн өсөлт, хөгжилд хүрсэн улсуудын туршлагыг судаллаа. Эдгээр улсын туршлагаас харахад гадаад худалдааны бодлогыг шат дараатай (импорт орлуулах, худалдааг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх, улмаар чөлөөт худалдааны бодлого хэрэгжүүлэх), тогтвортой хэрэгжүүлж ирсэн бөгөөд гадаад худалдааг хариуцсан яам, түүний дэргэд экспортыг дэмжих тусгай байгууллага ажиллуулах замаар өөрийн улсын гадаад худалдааг дэмжсэн байна. Эндээс харахад ихэнх улс оронд гадаад худалдааг дангаар хариуцан ажилладаг яамтай бөгөөд түүний дэргэд гадаад худалдааг дэмжих зохицуулалттай бие даасан байгууллага байдаг ажээ. Иймээс Монгол улсад гадаад худалдааг хариуцсан тусгай яам, түүний дэргэд худалдааг дэмжих институци дутагдаж байна. Гадаад худалдааг дангаар хариуцах яам бий болсноор төлбөрийн тэнцэл, гадаад валютын нөөц сайжрах, эдийн засагт бүтцийн өөрчлөлт хийх, үр ашиг нэмэгдэх ач холбогдолтой болно.

**ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ
(АМ.ДОЛЛАРААР, 30/ХІ ӨДРИЙН БАЙДЛААР)**





ЭДИЙН ЗАСГИЙН ДАРААГИЙН ХЯМРАЛ

Дэлхийн улс орнуудын эдийн засаг, мөнгөний бодлогын хамтын ажиллагаа, санхүүгийн тогтвортой байдал, олон улсын худалдааг дэмжиж, ажилгүйдлийн төвшинг бууруулахад анхаарах замаар тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангахад зорьдог байгууллага ОУВС-ын тэргүүн Кристин Лагард ач холбогдол өндөртэй чуулга уулзалтуудад хэлэх үгэнд үүлэн чөлөөний нарнаар дээрээ засахыг улс орнуудад анхааруулах болсон. Учир нь удахгүй үүл дахин хуралдаж, эдийн засагт хүндрэл учрах эрсдэлтэй байгаа тул энэ боломжийг ашиглаж реформ хийгээгүй улсуудад хүндрэл тулгарах аюултай байгаа аж. Тэгвэл тэрхүү болзошгүй хүндрэлийг хэрхэн томьёолж байгааг энэ удаагийн олон улсын эдийн засаг буланд онцлохоор шийдлээ.

БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ШААРДЛАГА

Дэлхийн санхүүгийн хямрал 2008 онд нүүрлэх үед томоохон эдийн засгууд уламжлалт бус мөнгөний бодлогыг хэрэгжүүлж, актив худалдан авах ажиллагаанд ихээхэн анхаарч бодлогын хүүг 0%, бүр зарим улсад үүнээс бага төвшинд хүргэсэн боловч бүтцийн өөрчлөлтийг төдий л сайн анхаараагүйг “Дэлхийн эдийн засгийн форум”-аас онцолжээ. Улмаар чухал реформуудыг хэрэгжүүлээгүйн улмаас дараагийн хямрал холгүй байгаа бөгөөд үр дүнд нь зэвсэгт хүчний салбарт нөлөөлж, сэргөлдөөнд хүргэх аюул байгаа аж.

Өмнөх хямрал засгийн газруудыг дампууруулах шахаж, тогтолцооны уналтад хүргэх эрсдэлтэй байсан. Бодлого тодорхойлогч нар чухал арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж чадсан ч зөвхөн шинж тэмдгийн эмчилгээг эдийн засагт үзүүлсэн. Өдгөө дэлхийн эдийн засаг хэвийн голдиролдоо хүрсэн ч, үнэн хэрэгтээ суурь өвчинг эмчилж хараахан чадаагүй байна. Тус эмчилгээний стратегид бүтцийн өөрчлөлт багтах бөгөөд ингэхдээ санхүүгийн болон ажиллах хүчний зах зээл, татварын тогтолцоо, боловсролын бодлогыг хамрах юм. Бүтцийн өөрчлөлтийг хангалттай хийгээгүйн улмаас Төв банкуудын нийлүүлсэн мөнгө зах зээлд зүй зохистой хувиарлагдалгүй, активын үнэ өсөхөд хүргэсэн. Тухайлбал, АНУ-д үл хөдлөх хөрөнгийн үнэ 2006 онд хөөсөрч дээд цэгтээ хүрснээс даруй 8% илүү

өссөн байна.

Инфляци өсөхийн хэрээр бодлогын хүүг улсууд чангалж эхэлсэн нь хөрөнгийн үнийн хөөс хагарахад хүргэх эрсдэлийг үүсгээд байна. Макро эдийн засгийн хамгийн хүчтэй “эмнүүдэд” тэсвэртэй болсон цаг үед энэ нь өмнөх хямралаас ч илүү аюул үүсгэх боломжтой. Түүхээс харвал энэ мэт алдаа нь эдийн засгаас ч хальсан байдаг. Учир нь тэгш бус байдал гаарах нь нийгмийн тогтворгүй байдал, терроризм, бүр дайнд хүргэдэг.



Дэлхийн эдийн засгийн өсөлт

ДЭЛХИЙН ХАМГИЙН ТОМ ЭДИЙН ЗАСАГ ТЭЛСЭЭР БАЙХ УУ?

АНУ-ын ажилгүйдлийн төвшин 3.7%-д хүрч сүүлийн 45 жилд байгаагүйгээр буураад байна. Мөн дундаж цалингийн хэмжээ өмнөх жилээс 3.4% өсч Америкчуудын хэрэглээнд зарах мөнгө нэмэгдэв. Тус улсын эдийн засаг зогсолтгүй өссөн түүхэн үзүүлэлтээр 2-т орохоор хэмжээнд хүрээд байгаа ч сайхан цаг мөнхөд үргэлжилдэггүйн адилаар хүндрэл хүлээж байгааг судалгаануудын үр дүн харуулж байна. Учир нь бизнесийн цикл болон түүхэн үзүүлэлтүүдийг харах юм бол АНУ-ын эдийн засаг 10 жилээс илүү хугацаанд

тэлдэггүй аж. 1980 оноос хойш 4 хямрал тохиолдоод байгаа, тухай бүрт ДНБ болон худалдааны өсөлт буурч, санхүүгийн салбар агшсан байна.

Дэлхийн эдийн засгийн түүхээс харвал 1945-1975 онд олонх улс банк санхүүгийн хямралаас ангид хамгийн ихдээ 4 улс л энэ хүндрэлтэй тулгардаг байжээ. Харин 1975 оноос банк санхүүгийн хямрал тохиолдох тоо эрс өсч дунджаар 13 улс жил бүр банк санхүүгийн хямралыг даван туулах шаардлага гардаг болсон байна. Үүнд нэг талаар банк санхүүгийн огцом хөгжил нөлөөтэй ч нөгөө талаар зохицуулалтын асуудал байсантай холбоотой юм. 2008 оны хямралын дараа тэдгээр асуудлыг шийдвэрлэх алхмууд хийсэн ч сууриар нь өөрчилж хараахан чадаагүй л байна.

Улс орнууд эдийн засгийн хэт өсөлтийг нөхцөлдүүлж чадахгүй байгаа ч хязгаарлагдмал хэмжээнд дэмжиж байгаа. АНУ-ын татварын бодлого зөөлөрч байгаа нь хэрэглээг нөхцөлдүүлэх ач холбогдолтой ч төсвийн алдагдал, засгийн газрын өрийг нэмэгдүүлсээр байна. Нөгөө талаар Холбооны нөөцийн төв банк бодлогын хүүгээ 2015 оноос хойш алгуур өсгөж байгаа нь тодорхой хэмжээнд хязгаарлалт болж байгаа билээ. Үүнийг дагаад Английн Төв банк бодлогын хүүгээ 2017 оноос нэмэгдүүлж, Европын Төв банк уламжлалт бус мөнгөний бодлогоо энэ оны эцэс гэхэд зогсоож, 2019 оноос бодлогын хүүгээ өсгөх хандлагатай байна. Төв банкнаас актив худалдан авалтын бодлогыг хэрэгжүүлж эхэлснээр хөрөнгийн зах зээлийг аварсан ч, засгийн газрын бондын өгөөжийг бууруулж, улмаар хөрөнгийн урсгалыг хөгжиж байгаа зах зээлүүд рүү чиглүүлсэн. Улс орнуудын ам.долларын зээлийн хэмжээ 2008 оноос хойш 4 дахин өссөн, одоо АНУ зэрэг томоохон эдийн засгууд мөнгөний бодлогыг чангаруулах үед тэдгээр улсаас ам.доллар гарч мөнгөн тэмдэгтийнх нь ханшийг сулруулан, тогтворгүй байдалд хүргэх аюул нүүрлэв.

ШИНЭ ДЭЛХИЙН ЭМГЭГ

Дэлхийн эдийн засгууд дараагийн хямрал болох үед шокийг давж туулахад бэлэн үү? Урьд хожид эдийн засаг суларч, хямрах үед Төв банкууд богино хугацааны бодлогын хүүгээр зохицуулалт хийдэг байсан бол 2008 оны хямралаас хойш энэ боломж хязгаарлагдмал болсон. Бодлогын хүү багагүй хугацаанд 0% дээр тогтсон ч, эдийн засгийн сэргэлт сул байж, уламжлалт бус бодлогын арга хэрэгсэлүүдийг хэрэгжүүлэх шаардлага тулгарсан. Өдгөө сэргэлт бий болсон ч

дараагийн хямрал ойрын үед болох юм бол бодлогын хэрэгсэлүүдийн үр нөлөө хомс буюу гар мухардах эрсдэлтэй байгаа. Мөн төсөв талаас эдийн засгийг сэргээхэд чиглэсэн зарцуулалтууд нь засгийн газруудын өрийг нэмэгдүүлсэн. Хөгжингүй эдийн засгуудын өрийн хэмжээг тэдгээрийн ДНБ-тэй харьцуулбал дунджаар 100% хүрсэн нь 2007 оноос хойш 30% өссөн үзүүлэлт аж. Төсвийн алдагдал, засгийн газрын өр нэмэгдэх нь нийгэм – улс төрийн хүчтэй эсэргүүцэлтэй тулдаг учраас энэ бололцоог хангалттай ашигласан гэж хэлж болох ба цаашид өсгөх боломж мөн хязгаарлагдмал юм.

Гэхдээ эдийн засгийн бодлогоос гадна улс төрийн бодлого хамгийн том эрсдэлийг үүсгээд байна. 10 жилийн өмнө санхүүгийн зах зээл доргиж, улс орнуудын эдийн засагт хүчтэй сөрөг нөлөө үзүүлэх үед засгийн газар, төв банкууд амжилттай хамтран ажиллаж, Их 20-ийн зорилт, төлөвлөгөөг өргөжүүлснээр бүр том хямралаас сэргийлж чадсан. Харин одоо нөхцөл байдал харьцуулшгүй өөр болжээ. Трампын засаг захиргаа протекционист гадаад худалдааны бодлого явуулж, Их Британи нь Брекситийг сонгож Европын холбооноос гарч байгаа зэрэг нь дэлхий нийтийн хамтын ажиллагаанд таагүй уур амьсгал авчирлаа. Нөгөө талаар хөгжингүй болон хөгжиж байгаа орнуудын улс төрд популист хандлага газар авч, технологийн саад, дүрвэгсэдийн хямрал, үндсэрхэг үзэл зэрэг асуудал цэцэглэж байгаа нь дайран дээр давс нэмлээ. 2008 онд хямралын гал авалцаж эхлэх үед мөнгө болон төсвийн бодлогууд, дипломат харилцаа амжилттай ажиллаж түймрийг газар авхуулчаагүй ч цаашид дахин хямрал болох үед хэрхэн ажиллах нь эргэлзээтэй асуудал болоод байна. Тиймээс ч ОУВС-аас үүл хуралдаж байгаа энэ цаг үед бүтцийн реформ хийхийг анхааруулж байгааг дутуугаар үнэлж хэрхэвч болохгүй.

Н.Батжин

Эх сурвалж:

<https://www.weforum.org/agenda/2018/11/the-next-economic-crisis-could-cause-a-global-conflict-heres-why/>

<https://www.economist.com/special-report/2018/10/13/another-economic-downturn-is-just-a-matter-of-time>



ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМ ГЭЖ ЮУ ВЭ?

Иргэн, хуулийн этгээдийн хооронд мөнгөн хөрөнгийг шилжүүлэхэд оролцох байгууллага, ашиглах төлбөрийн хэрэгсэл ба техник, технологийн дэд бүтэц, эдгээрийг зохицуулсан хууль тогтоомжийг бүхэлд нь төлбөрийн систем гэнэ.



Бэлэн мөнгө



Төлбөрийн даалгавар, нэхэмжлэл



Төлбөрийн карт



Цахим мөнгө



Интернэт банк



Мобайл банк



Мөнгөн гуйвуулга



Биллинг



Үндэсний төлбөрийн системийн тухай хууль

Монголбанкнаас баталсан дүрэм, журам.

2. Төлбөрийн хэрэгсэл

Эдгээр төлбөрийн хэрэгсэл, системийг Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн хүрээнд холбогдох дүрэм, журмыг гаргаж Монголбанк зохицуулна.



Банк, зөвшөөрөл бүхий

Банк бус санхүүгийн байгууллага, ба Финтек компани

4. Үйлчилгээ үзүүлэгч

Банкууд болон Монголбанкнаас холбогдох зөвшөөрлийг авсан ББСБ болон Финтек ХХК нь төлбөрийн системд үйл ажиллагаа явуулж, төлбөрийн үйлчилгээ үзүүлнэ.

1. Төлбөрийн хэрэгсэл

Монгол Улсад эдгээр төлбөрийн хэрэгслийг голчлон хэрэглэж байна.



3. Дэд бүтэц


Монгол Улсад төлбөр тооцоо нь Их дүнтэй төлбөрийн систем, Бага дүнтэй төлбөрийн систем, Төлбөрийн картан систем гэсэн гурван үндсэн сувгаар дамждаг.



- Иргэд
- Хуулийн этгээд

5. Хэрэглэгч

Эдгээр байгууллагын үзүүлэх төлбөрийн үйлчилгээг нийт ард иргэд болон бүх төрлийн компани, аж ахуйн нэгжүүд ашиглах боломжтой.



6. Төлбөрийн картын хэрэглээ

Сүүлийн жилүүдэд бэлэн бус төлбөрийн хэрэгслийн хэрэглээ хурдацтайгаар нэмэгдэж байгаа бөгөөд ялангуяа төлбөрийн картыг ихээр ашиглаж байна. Төлбөрийн картыг бэлэн бус төлбөрт ашиглах нь ихэссээр 2017 онд АТМ-аас бэлэн мөнгө авахаас олон болсон.



Төлбөрийн картан зах зээлийн дийлэнх буюу 73%-ийг ₮ карт дангаараа эзэлдэг байна.



7. Гүйлгээ дамжих хурд

Төлбөр илгээгч банк (Банк А) 1 сая төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээг илгээсэн даруйд их дүнтэй төлбөрийн "Банксүлжээ" систем 1-2 секундийн дотор гүйлгээг хүлээн авагч банк (Банк Б)-д дамжуулна.



Бага дүнтэй төлбөрийн систем нь гүйлгээг дамжуулсан даруйд гүйцэтгэх бодит цагийн горимд ажиллах бөгөөд харилцагч гүйлгээг илгээснээс 1-4 секундийн дотор хүлээн авагч иргэний дансанд мөнгөн хөрөнгийг тусгаж, ашиглах боломжтой болно.

АРВАН НЭГДҮГЭЭР САРД 1.2 ТОНН АЛТ ХУДАЛДАН АВЛАА

Монголбанк 2018 оны 11 дүгээр сард 1.2 тонн алт худалдан авсан нь өмнөх оны мөн үетэй ижил хэмжээнд байна.

Харин Монголбанк 2018 оны эхний 11 сард 18.9 тонн алт худалдан авсан нь өмнөх оны мөн үетэй ижил хэмжээнд байна.

2018 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 93.3 кг алт, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 41.6 кг алтыг худалдаж авсан үзүүлэлттэй байна.

2018 оны 11 дүгээр сарын байдлаар 1 грамм алт худалдан авах Монголбанкны дундаж үнэ 100,995.34 төгрөг байлаа.



График 1. 2000-2018 онд Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ





График 2. 2018 оны 11 дүгээр сард Монголбанкны алт худалдан авсан үнэ

ВАЛЮТ АРИЛЖААНЫ ЦАХИМ ТАЛБАРЫН АРИЛЖААНЫ ТОЙМ

БХВАЦТ-ыг 2017/4/10-нд нэвтрүүлснээс хойш 2018/11/30-ний хооронд 523,8 сая ам.долларын болон 112.4 сая юанийн нийт 878 удаагийн арилжаа БХВАЦТ-т хийгдээд байна.





АЯНЫГ ДЭМЖИГЧ

PSM)))

PROJECT

ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН
ШИНЭЧЛЭЛ ТӨСӨЛ

ЦАХИМ ЭРИНД ЦАХИМ ТӨЛБӨР ТООЦОО АЯН

2018.10.10-12.10



www.mongolbank.mn



[@mongolbank.mn](https://twitter.com/mongolbank.mn)



[Mongolbank.mn](https://www.facebook.com/Mongolbank.mn)



[Mongolbankmn](https://www.youtube.com/Mongolbankmn)